

Монгол хэлний цаас (paper) гэдэг үгийн
гарал, бүтцийн хувьсал хөгжил

ШИОТАНИ Шигэки*

Япон Улс, Осака муж, Осакагийн Их Сургууль,
Хүмүүнлэгийн ухааны салбар

Received: 30 August 2025 / Accepted: 19 September 2025 / Published: 30 December 2025

Хураангуй:

1. Монгол хэлний цаас (paper) гэдэг үг нь монгол хэлний уугуул үг биш, угтаа хятад гаралтай үг мөн. Тус үг нь согд хэл болон перс хэлээр дамжин монгол хэлэнд хоёр өөр замаар, өөрөөр хэлбэл а. эртний түрэг хэлний А: кауз хэлбэрээс цаас, б. эртний уйгур хэлний В: кегде хэлбэрээс хэгд гэсэн хэлбэрээр тус тус хувьсан иржээ.

2. Эртний түрэг хэлнээс XIII зуунаас өмнөх үеийн эртний монгол хэлэнд орохдоо а. үгийн эхний гийгүүлэгч *k- > ċ-ийн тагнайшил, б. үгийн төгсгөлийн [-z] авианы хувьсал, с. монгол хэлний нэрээс нэр үг бүтээх -sun дагаврыг араас нь залгах гэх зэрэг гурван янзын авиа болон хэлбэрийн өөрчлөлт орсон байна.

3. Ялангуяа А: кауз хэлбэрээс үгийн төгсгөлийн [-z] авиа нь нэг бол [-s], эсвэл [-r] гэсэн хоёр янзаар хувьссан байдлаас эртний монгол хэлний хэлбэрийг *ċayassun болон *ċayarsun гэж таамагласан болно.

4. Эхний *ċayassun хэлбэрээс гийгүүлэгчийн нийлэмж нь *-ss- > -ls- > -s- зэргээр хувьссан байдлаас -S- хэлбэрт аялгуу, бас сүүлчийн *ċayarsun хэлбэрээс *-rs- > -rs- зэргээр хөгжсөн байдлаас -R- хэлбэрт аялгуу болон хоёр хуваагдан хөгжсөн бололтой. Үүнийг монгол төрөл хэлний төв аялгуу болон хойд зүгийн аялгуу гэж тус тус нэрлэв. Тийм учраас Мо. *ċayalsun ~ *ċayarsun гэж -l- ~ -r- хоёр гийгүүлэгч сэлгэсэн хэрэг огт биш гэж үзэв.

5. В: кегде хэлбэр нь эртний уйгур хэлнээс эртний монгол хэлээр дамжин дундад үеийн монгол хэлэнд орж ирсэн бөгөөд тэр нь одоогийн бао-ань, дуншаан, канжя зэрэг гурван хэлэнд бүрэн хадгалагджээ. Үүнийг монгол төрөл хэлний өмнө зүгийн аялгуу гэж нэрлэв. Харин одоо үеийн монгол хэлэнд энэхүү үг хэрэглэгдэхээ байчхаад, бараг мартагдсан үг болсон байна.

6. Харин хүүдас (sheet of paper; page) гэдэг үгийн тухайд энэ нь гаднын харь үг биш, монгол хэлний жинхэнэ уугуул үг мөн хэмээн дүгнэсэн болно.

* © Shiotani Shigeki, 2025, Email: shiotani.shigeki@gmail.com



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license.

Түлхүүр үгс: монгол бичгийн хэл čayasun, эртний түрэг хэл qayaz, эртний уйгур хэл kegde, тагнайшил ба ротацизм, монгол төрөл хэлнүүд дэх -S- хэлбэрт аялгуу ба -R- хэлбэрт аялгуу, монгол бичгийн хэл qayudasun

The Origin and Structural Development of the Mongolian Word Tsaas (Paper)

SHIOTANI Shigeki

Graduate School of Humanities, The University of Osaka, Osaka, Japan

Abstract:

1. The Mongolian word цаас “paper” does not belong to the same word family as цагаан “white” and цац “snow”, despite what is commonly stated by Mongolian scholars. In other words, the word цаас is not originally of Mongolian origin.

2. It originates from Chinese, passing through Sogdian and Persian, then through Ancient Turkic and Ancient Uighur, before eventually entering the Mongolian language. In other words, its path follows: Chinese > Sogdian → Persian kāghaz > Ancient Turkic qayaz (> Mongolian цаас) ~ Ancient Uighur kegde (> Mongolian хэгд) in two ways.

3. When Ancient Turkic qayaz “paper” entered Mongolian, the final consonant -z changed in two ways: one became -r (< -z) through rhotacism, while the other became -s (< -z) due to sound substitution, as Mongolian lacks word-final -z. This phenomenon resulted in two distinct branches within the Mongolic languages : the S-dialects and the R-dialects of the word čayasun.

4. As for the reconstruction of the Ancient Mongolian form, it was most likely *čāyassun ~ *čāyarsun (< Ancient Turkic *kāyaz) based on linguistic evidence, including Sogdian and Persian words that feature a long vowel in the first syllable. In other words, the Written Mongolian čayasun had a long vowel in the first syllable, as in čāyassun, and not in the second syllable, as in *čayāsun.

5. On the other hand, it can be concluded that the word qayudasun (хүүдас) “sheet of paper; page” is of Mongolian origin, as it consists of a word family including хүү “off”, хүүл “vt. peel off, skin” (> хүүлдас > хүүдас), and хүүр “vi. come off, be taken off”, as well as a series of adverbs such as хара “apart”, хүр “off, apart”, and хүү “off”.

Key words: Written Mongolian čayasun, Ancient Turkic qayaz, Ancient Uighur kegde, Palatalization and Rhotacism, The S-dialects and R-dialects of the Mongolic languages, Written Mongolian qayudasun

1. Удиртгал

Тус өгүүлэлдээ монгол хэлний цаас (paper) гэдэг үгийн гарал, бүтцийн хувьсал хөгжлийг тус үгийн авиа, хэлбэр, утга болон алтайн язгуурын хэлнүүдийн үүднээс тодруулахыг зорилоо. Үүний зэрэгцээ монгол хэлний хүүдас (sheet of paper; page) гэдэг үгийн гарлыг ч бас хөөж үзэв.

2. Судалгааны арга зүй

Тус өгүүллийн судалгааны хэрэглэгдэхүүн нь алтайн язгуурын хэлнүүд буюу түрэг, монгол, манж-түнгүс төрөл хэлний эртний ба эдүгээгийн гол гол толь бичгүүд болно. Ялангуяа эртний түрэг, эртний уйгур хэлний толь бичгийг гол судлагдахуунаа болгож, улмаар монгол хэлний байдалтай харьцуулан үзсэн билээ. Арга зүйн хувьд хэлний цуваа цаг болон хам цагийн үүднээс, мөн хэлний харилцан нөлөөлөл, нутгийн аялгуу, хэлний тархац зэрэг түүхэн

харьцуулсан хэл шинжлэлийн үүднээс монгол хэлний цаас (paper) гэдэг үгийн гарал болон бүтцийн хувьсал хөгжлийг мөшгөв. Монгол хэлний түүхэн сурвалж бичгүүд нь XIII зуунаас эхэлдэг ч, түүнээс өмнөх үеийн эртний монгол хэл (Ancient Mongolian)-ний байдлыг төсөөлөн тодруулахыг оролдов.

3. Монгол хэлний цаас (paper) гэдэг үгийн гарлын талаарх ерөнхий үзэл

Тус үгийг монгол судлаачид ер нь $\sqrt{\text{ца-}}$ язгууртай, “white” гэсэн утгатай монгол гаралтай үг мөн гэж үзсээр ирсэн байна. Тухайлбал, ШУА ХЗХ (1966:67-68), Б.Ринчен (1966:47-48), Ш.Лувсанвандан (1968:118), Д.Төмөртоогоо (2018: 330), Ц.Өнөрбаян (2021:15-16) нар үндсэндээ санал нэгтэй, энэхүү үзлийг дэмжиж байна. Зарим бүтээлээс доор эшилбэл:

... Зарим язгуур нэлээд олон үгэнд тохиолдоно. Жишээлбэл ца- язгуур цаас, цайх, цас, цагаан гэх мэт үгэнд байна. Ийм үгийг нэгэн язгуурт үгс гэдэг (ШУА ХЗХ 1966:67-68).

... орчин цагийн монгол хэлний “ца-” язгууртай үгсийг олж харьцуулсан ажиглалт хийнэ. “Цас, цан, цаас, цагаан, ... цал, ... цай- ...” гэх мэт “ца-” язгууртай төрөл байж болох ерөнхий утгатай үгсийг олж тогтооно... Дээрх түүхэн төрөл үгсийн язгуурын ерөнхий утга нь “цагаан өнгө болно” (Ц.Өнөрбаян 2021:15-16) гэх мэт.

Энэхүү саналыг дэмжиж байгаа баримт бол XIII зууны эхээс дунд хүртэл зохиогдсон “Монголын нууц товчоо” бөгөөд түүний 203-р зүйлд: ... kökō bičig čaga’an ča’alsun-dur debterlegsen-i bü ye’üdketügei... (... хөх бичиг цагаан цаасанд дэвтэрлэснийг бүү егүүтгэтүгэй /өөрчилтүгэй/... (Д. Цэрэнсодном 2000:134)) гэж гарч байна.

Үүнд “цагаан цаас” гэж цагаан гэдэг тэмдэг нэр нь цаас гэдгийн тодотгол болон хамтдаа хэрэглэж байгаа нь энэ хоёр үгийг гарал нэгтэй буюу нэг язгууртай үг гэсэн сэтгэгдэл төрүүлж байна.

Харин алтай хэл шинжээч Г.Й. Рамстедт “Халимаг хэлний толь бичиг (Kalmückisches Wörterbuch)”-тээ [čaga-sun < chin.?] (G.J. Ramstedt 1935:424) гэж дурдаад, цаас гэдэг үгийг хятад гаралтай үг байж магадгүй, гэхдээ эргэлзээтэй гэжээ. Гэвч энэ нь зөвхөн таамаглал төдий байх бөгөөд үүнээс илүү тодорхой ямар ч мэдээ өгөөгүй байна.

Харин сүүлийн үеийн цахим мэдээ болох Wikitionary дээр цаас гэдэг үгийг [Borrowed from Sogdian /kāyadā/, possibly ultimately from 紙 (zhǐ, “paper”)]¹⁾ гэж дурдаад, энэхүү үгийг иран хэлний бүлэгт багтдаг согд хэлнээс монгол хэлэнд орж ирсэн бөгөөд эцсийн эцэст бараг хятад үгнээс гарал үүсэлтэй байх гэж дурджээ. Энэ үзэл нь Рамстедт-ийн саналыг дэмжиж, илүү тодруулсан боловч хятад: 紙 (zhǐ) > согд. /kāyadā/ > монгол. цаас гэсэн гурван үгэнд ямар авианы хувьсал үүссэн явцыг ер тайлбарлаагүй байна.

4. Түүхийн баримтаас цаас (paper) гэдэг үгийн гарлыг мөшгөх нь

Хэлний үүднээс ерөнхийд нь хэлэхэд биеийн эрхтний нэр, тооны нэр гэвэл тус хэлний уугуул үг буюу үндсэн үг байх боломж их байдаг бол бодит юмны нэр, ялангуяа шинэ юмны нэрийтгэл нь уугуул үгээр орлуулж орчуулах юм уу, эсвэл харь үгийг тэр чигээр нь зээлж авах боломж их байдаг. Жишээлбэл: цай (tea), тамхи (tobacco) гэвэл гадаад хэлнээс шууд зээлсэн харь үг, зурагт (television) гэвэл зураг радио гэдгийг хурааж монголчилсон хэлбэр гэх мэт.

Тэгвэл цаас (paper) гэдэг үг нь чухам монгол хэлний уугуул үг үү, харь үг үү, аль нь вэ? Монголд эртнээс нааш цаасыг өөрсдөө хийх арга технологи байгаагүй нь лавтай ч цаас гэдэг үгийг шууд харь үг гэж дүгнэж болохгүй нь бас мэдээжийн хэрэг.

Юуны өмнө Төв Ази дахь цаасны түүхээс (Kuwabara Jitsuzō 1968) авч үзье. Одоогийн цаас хийх түүх нь эртний Хятадад буюу манай эриний 105 онд Хан гүрний үед анх үүссэн бөгөөд

баруун зүгийн орнуудад өргөн тархсан нь VIII зууны дунд үе буюу 751 онд Хятадын Тан улс болон Аббасидын Исламын эзэнт гүрний хооронд болсон “Талас голын тулалдаан (The Battle of Talas)”-аас эх үүсэлтэй ажээ. Тэр тулалдаанд олзлогдсон Тан улсын цэргүүдийн зарим нь цаас үйлдвэрлэгч байсан бөгөөд тэднийг Төв Азийн Самарканд руу аваачин маалинга (flax) ургамлыг түүхий эд болгон ашиглаж цаас үйлдвэрлэж эхэлсэн түүхтэй. Тэр үеэс эхлэн цаас хийх арга нь Баруун Исламын ертөнц болон Төв Азид аажмаар тархсан гэдэг²⁾. Энэ түүхэн үйл явдлаас тодорхой болсон зүйл гэвэл: одоогийн цаас хийх арга нь анх Хятадад үүссэн бөгөөд VIII зууны дунд үед болсон “Талас голын тулалдаан”-аас хойш цаас үйлдвэрлэх арга дэлхий даяар аажмаар тархан дэлгэрсэн гэсэн үг.

Германы хятад судлаач эрдэмтэн Фридрих Хирт “Цаасыг Хятадад зохион бүтээсэн нь (Die Erfindung des Papiers in China)” гэсэн өгүүлэлдээ “Перс, араб хэлээр цаасыг *kaghaz* эсвэл *kaghad* гэдэг. энэтхэгийн *kaghaz* гэдэг үгтэй адил. Аль аль нь хятад хэлний 「穀紙」 *ku-chih* (хуучин дуудлага нь: *kok-dz*) гэдэг үгийн гажсан дуудлага юм” (Friedrich Hirth (1890:12) гэжээ.

Тэр бээр перс хэлний *kaghaz* (paper) гэдэг үгийг аль хэдийн хятад хэлний 「穀紙」 гэдгээс гарал үүсэлтэй гэж дурдсан нь дээрх түүхэн үйл явдалтай тулгаж үзэхээр тун оновчтой санал гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл цаас үйлдвэрлэгч хятад олзлогдогчдын ярьдаг байсан 「穀紙」 [*kokdz*] (paper) гэсэн үгийг перс-араб хүмүүс *kaghaz* мэт дуудлагаар сонсож мэдэрсэн гэсэн утгатай юм.

3-р хэсэгт дурдсанчлан хятад: 紙 (*zhì*) > согд: /*kāyadā*/ (> монгол: цаас) гэсэн байдлаар хувьссан биш, харин үнэн хэрэг дээрээ хятад: 穀紙 (*gǔzhì*) > согд: /*kāyadā*/ ~ перс: *kaghaz* (> монгол: цаас) гэсэн байдлаар хувьссан гэж үзвэл зохино гэж бид бодож байна.

Энд хятад хэлний 「穀紙」 гэсэн үгийн VIII зууны үеийн дуудлага болон цаасны түүхий эдийн талаар тодруулъя. Үүнд:

「穀紙」 / Одоо үеийн дуудлага: [*gǔzhì*] /*kutʃi*/ (←穀 *gǔ* + 紙 *zhì*)

дундад үеийн дуудлага : /*kuk-teie*/ (VI-X зууны үе)

→ перс-араб хүмүүсийн сонссон дуудлага (таамагласан авиа) : **kōgza*

> согд: *kāyadā* /*ka:yaða:*/ (IV-IX зууны үе)

> перс: *kaghaz* /*ka:ʔaz*/

Утга нь: 「穀紙」 (Яп. *koku-shi*) гэдгийн түүхий эд бол 「楮」 (Яп. *kōzo*) юм.

「楮」 / 1. (ургамал) үст дургана, 2. (бичиг) цаас

Жич:

1. Ер нь дээр үед ургамал, модны хальсыг ашиглаж цаас хийдэг байжээ.

2. Согд хэл нь иран хэлний зүүн бүлэгт, перс хэл нь иран хэлний баруун бүлэгт багтдаг төрөл хэл бөгөөд согд хэл бол одоо мөхсөн хэл болно. Согд хэл нь Төв Азийн хятад болон иран худалдаачдын дунд нийтлэг хэл (Lingua franca) байсан бөгөөд тэндхийн эдийн засаг, улс төрийн хувьд нэлээн чухал үүрэг гүйцэтгэж байсан ажээ.

5. Эртний түрэг хэлний *qayaz* /*kaʔaz*/ (paper) болон бусад хэлбэрүүдийн учир

4-р хэсэгт дурдсанчлан хятад хэлнээс гаралтай үг нь согд хэл болон перс хэлээр дамжин, хятад: 穀紙 /*kuk-teie*/ > **kōgza* > согд: /*kāyadā*/ ~ перс: *kaghaz* ... > монгол: цаас гэхчлэн хувьссан гэж үзвэл перс хэл (дундад үеийн перс хэл) болон монгол хэл (дундад үеийн монгол хэл) хоёрын хоорондох харилцаа буюу VII-XIII зууны үеийн эртний түрэг хэлний байдлыг тодруулах хэрэгтэй байна.

Эртний түрэг хэлэнд АТ. *kaʔad*, *qayaz*, *kegde*, *kegede*, *kaʔid*, *qayat* (бумага) гэх мэт 6 янзаар тохиолддог (Древнетюркский словарь 1969) бөгөөд үүнийг үгийн төгсгөлийн гийгүүлэгчийн бүтэх аргаар нь 3 ангилан, [-*ǰ*] > [-*z*] > [-*d*] гэсэн гурван шат дамжиж хувьсаж ирсэн байх гэж таамаглаж байна. Үүнд:

1-р шатанд / шүргэх авиа [-ð] хэлбэртэй: каҗа᠔ (← Согд хэлний *kāyaḍā* /ка:уа᠔а:/ гэдгээс орж ирсэн бололтой. Харин энэ хэлбэр одоогийн түрэг төрөл хэлний ямар ч хэлэнд үлдсэнгүй.)

2-р шатанд / шүргэх авиа [-z] хэлбэртэй: qayaz (> Энэ хэлбэрээс жишээ нь: одоогийн татар, киргиз, казах, туркмен, азербайжан, уйгур, узбек гэх мэт олон түрэг төрөл хэлнүүд болон монгол төрөл хэлний нэг болох могол хэлэнд ч бас хадгалагджээ.)

3-р шатанд / хамжих авиа [-d] хэлбэртэй: kayid (qayāt) / kegde (kegede) (> kayid хэлбэрээс: осман түрэг хэл (XIV-XIX зууны сүүлч), одоо үеийн түрэг хэл, салар хэлэнд бас хадгалагджээ.)

(> kegde хэлбэрээс: эртний уйгур хэл (IX-XIV зуун), баруун ёгор (Western Yügur) хэлэнд л хадгалагджээ.)

Жич: 3-р шатны [-d] хэлбэртэй үг угтаа *qayad хэлбэрээс *qayad (→ kayid) ~ *keged (→ kegde) гэх мэтээр эгшиг a ~ e сэлгэснээр үүссэн бололтой байна.

Дээрх жишээнүүдээс үзүүлбэл:

2-р шатны [-z] авиатай хэлбэрээс: татар. кагаз, киргиз. кагаз, казах. қағаз, туркмен. кагыз, азербайжан. кағыз, уйгур. qeqhez, узбек. қоғоз (qog'oz) болжээ. Мөн Афганистаны могол хэлэнд kāyaz “Papier” гэдэг үгийг хэрэглэж байсан гэсэн тэмдэгдэл байна (G.J. Ramstedt 1905).

3-р шатны [-d] авиатай kayid хэлбэрээс: осман түрэг. kyāghid /кә:үшд/, түрэг. кағит, салар. hahoute /ха:хәт/ болжээ.

3-р шатны [-d] авиатай kegde хэлбэрээс: эртний уйгур kegde, баруун ёгор kedie болжээ. Ташрамд хэлэхэд XIV зууны үед зохиогдсон *Мукаддимат ал-Адаб* толь бичигт монгол хэлний čālsun (бумага) гэдэгт таарах дундад үеийн түрэг хэлний үг нь MqTur. kayaz ~ kāyaz (131, 293), kayad ~ kāyad (251) гэсэн 4 янзаар байдгийг онцлон тэмдэглэе (Н.Н. Поппе 1938).

6. Монгол төрөл хэлнүүд дэх čayasun (paper) гэдэг үгийн учир

Монгол төрөл хэлнүүдийн үүднээс čayasun (paper) гэдэг үгийг авч үзвэл үгийн дунд а) -l- хэлбэртэй, б) -Ø- (тэг) хэлбэртэй, в) -r- хэлбэртэй гэсэн 3 янзаар гардаг нь мэдэгдэж байна. Үүнд:

а) -l- хэлбэртэй жишээ:

монгол бичгийн хэл³⁾ (Ковалевский, Голстунский, Lessing): čayalsun

Монголын нууц товчоо (XIII зууны эхээс дунд): ča'alsun (察阿勒孫) (8:31:04)

華夷訳語 (*Hua-yi yi-yi*) (1389): ča'alsun (察阿勒孫) (1:10b8)

Мукаддимат ал-Адаб (XIV зууны үе): čālsun (131, 251, 293)

蘆龍塞略 (*Lulong sai Lüe*) (1610): ča'alsun (察阿勒孫)

монгол хэл (хүжү): qaalsi [tɕɑ:lɕi] (~ qaalzi [tɕɑ:lɕi])

монгол хэл (миньхэ): chersi [tʂə:ɕi] (< čarsi < *čālsu⁴⁾)

б) -Ø- (тэг) хэлбэртэй жишээ:

монгол бичгийн хэл (Schmidt, Ковалевский, Голстунский, Lessing): čayasun

тод бичиг: cāsun [tɕɑ:sun]

ойрд: [tɕɑ:sn]

халимаг: цаасн [tɕɑ:sn]

халх: цаас(ан) [tɕɑ:s(ə)n]

зүүн ёгор: [tʃɑ:sə]

дагуур: [tʃɑ:s]

в) -r- хэлбэртэй жишээ:

монгол бичгийн хэл (Lessing): čayarsun

буриад: саархан [sa:rhan]

шинэхэн буриад: [sa:rhan]

хуучин барга: [sa:rɔ]


хамниган буриад (өвөр монгол): [tɕɑ:rɕon]

хамниган (орос): цаарса(н) [tɕɑ:rsa(n)]

дархад, хотгойд (Монгол): цаарс [tsa:rs]

Дээрх байдлыг цуваа цагийн үүднээс үзэхэд энэхүү цаас гэдэг үг нь XIII, XIV зууны дундад үеийн монгол хэлэнд үгийн дунд -l- хэлбэртэй байснаа сүүлдээ ихэнх хэл аялгуунд [l] нь гээгдсэн (-l- > -Ø- / #...CV_·sun) харагдаж байна.

Харин хам цаг болон нутгийн аялгууны тархцын үүднээс үзвэл халх, ойрд, халимаг зэрэг монгол хэлний төв аялгуунууд болон монгол төрөл зүүн ёгор, дагуур хэлэнд бүгд [l] нь гээгдсэн, -Ø- (тэг) хэлбэртэй үлдсэн байхад хоёр монгол хэлэнд л -l- хэлбэртэй үлджээ. Харин Монгол Улсын дархад, хотгойд болон буриад хэлний хэд хэдэн аялгуу буюу хойд зүгийн монгол аялгуунуудад -r- хэлбэртэй хадгалагджээ.



Зураг 1. Монгол төрөл хэлнүүд дэх цаас үгийн хэлбэрийн тархац

Жич: Алтайн язгуурын хэлнүүдийн үүднээс үзэхэд дээрх b) -Ø- (тэг) хэлбэртэй caasun гэдгээс Хятад дахь манж-түнгүс төрөл эвенк, орчон хэл болон түрэг төрлийн тува хэлэнд тус тус орсныг онцлон тэмдэглэе⁵⁾.

манж-түнгүс төрөл хэл: эвенк. [sa:sɔŋ], орчон. [ʃa:ʃɔŋ]

түрэг төрөл хэл: тува. саазын [sa:zin]

Энд тусгайлан дурдууштай нэг зүйл байна. Энэхүү -l- хэлбэртэй, -r- хэлбэртэй хоёр үг буюу caalsun, caarsun гэх хоёр үгийн харьцааг ер нь монгол хэлний судлаачид -l-~r- сэлгэсэн юм уу, эсвэл -l- > -r- болж өөрчлөгдсөн гэж үздэг байна. Жишээлбэл: *Этимологический словарь монгольских языков* (2015:129-130) бүтээлд энэхүү үгийн гарлыг доорх байдлаар бичжээ.

caan (←*ca-γan) (белый) (129) → [caγa-lsun] > caasun (бумага) (130)
> caarsun (130)

Өөрөөр хэлбэл caalsun (бумага) гэдгээс caasun, caarsun хоёр тус тус үүссэн бөгөөд угтаа caan (белый) гэдэгтэй нэг язгуурын үг гэжээ. Харин бид caalsun > caarsun юм уу, эсвэл caalsun ~ caarsun гэсэн аль ч саналыг нь дэмжихгүй, угтаа буруу үзэл гэж үзэж байна⁶⁾.

7. XIII зуунаас өмнөх үеийн монгол хэлний авианы хувьслыг таамаглах нь

5-р бүлэгт дурдсанчилан цаас (paper) гэдэг утгатай эртний түрэг хэлний 3 шат дамжин хувьссан хэд хэдэн хувилбаруудаас монгол бичгийн хэлний caasun, дундад үеийн монгол хэлний ca'alsun зэрэг үгэнд шууд холбогдохуйц чухал хэлбэр нь 2-р шатны [-z] хэлбэртэй caaz /kaaz/ болон 3-р шатны [-d] хэлбэртэй kedge гэсэн хоёр хэлбэр гэж үзэж байна.

VII-XIII зууны үеийн эртний түрэг хэлний А: kaγaz хэлбэр нь монгол хэлний төв болон хойд зүгийн аялгуунуудтай холбогдох боломжтой. Аль эсвэл IX-XIV зууны үеийн эртний уйгур хэл”-ний В: kegde хэлбэр нь монгол хэлний өмнө зүгийн аялгуунуудтай тус тус холбогдох боломжтой байж гэж хоёр хувааж үзэж болох байна.

7.1 Эртний түрэг хэлний А: kaγaz хэлбэрээс хувьсах нь

Цуваа цагийн үүднээс үзвэл эртний түрэг хэлний А: kaγaz хэлбэртэй холбогдох монгол хэлний хэлбэр нь цаас гэсэн үг мөн бөгөөд энэ хоёр үгийн холбоог тайлбарлахын тулд 1. үгийн эхний гийгүүлэгч *k- > č-ийн тагнайшил, 2. үгийн төгсгөлийн [-z] авианы хувьсал, 3. монгол хэлний нэрээс нэр үг бүтээх -sun/-sün дагавар гэсэн 3 зүйлийг тодруулах хэрэгтэй байна.

7.1.1. Үгийн эхний гийгүүлэгч *k > č-ийн тагнайшил

Эртний түрэг хэлний kaγaz хэлбэрийг XIII зууны монгол хэлний ča'alsun хэлбэртэй харьцуулан үзэхэд XIII зуунаас өмнөх үед үгийн эхний гийгүүлэгч *k-> (*kj->) č-ийн тагнайшил (Palatalization)⁷⁾ үүссэн байх магадлалтай байна.

Ер нь XIII зуунаас өмнөх үеийн эртний түрэг хэл (АТ.) болон XIII зуунаас хойших монгол хэл (монгол бичгийн хэл (Мо.), дундад үеийн монгол хэл (ММо.)-ийг багтаана) хоёрын хоорондох хэлний үзэгдэл бол үгийн эхэн, дунд орсон АТ. k / γ/g гийгүүлэгч нь тагнайшиж Мо. č/ĵ болж хувьссан тохиолдол⁸⁾ цөөнгүй харагдаж байна. Үүнд:

1. Дуугүй гийгүүлэгч АТ. k > Мо. č (→ ĵ) болсон жишээ:

АТ. *kičig* “маленький” > ММо. —, Мо. *ĵĵig* (жигиг) “small, little”

Жич: эртний түрэг хэлнээс монгол хэлэнд орохдоо АТ. *kičig* > *čičig → *ĵičig → Мо. *ĵĵig* болж тагнайшсан бөгөөд дундад үеийн монгол хэлэнд *ĵĵig* (жигиг) гэдэг үг огт тэмдэглэгдээгүй. Тухайн үед “жигиг” гэсэн утгаар “өчүүхэн” гэсэн үгийг л хэрэглэдэг байсан ажээ. cf. МНТ *üčü'ügen* (不出兀堅), *üčügen* (不出干) 《小》, МqMo. *hüčūken* (189a), *öčūken* (273a) “маленький” гэх мэт.

2. Дуутай гийгүүлэгч АТ. γ/g > Мо. ĵ болсон жишээ:

АТ. *kürgek* “лопата” > МqMo. *kürjek* (230a) “лопата” → Мо. *kürje* (хүрз) “shovel”

АТ. *yoγan* “толстый” < РТ. **joγān* > МqMo. *juja'an* ~ *jujān* (210a, 210b) “толстый” → Мо. *jujaγan* (зузаан) “thick”

Жич: Сүүлчийн жишээ нь эртний түрэг хэл (АТ.)-ний өмнөх шатны өвөг түрэг хэл (Proto-Turkic languages)-нээс монгол хэлэнд орсон бололтой. Энэ байдлаас үзэхэд эртний түрэг хэл, монгол хэлний хооронд дуугүй гийгүүлэгч АТ. k : Мо. č, бас дуутай гийгүүлэгч АТ. γ/g : Мо. ĵ тохиролцох нь түгээмэл биш ч гэсэн, ер нь авиа зүйн хувьд байж болмоор үзэгдэл гэж хэлж болохоор байна.

Нэмж хэлэхэд слав хэлний бүлгийн өмнөд славд багтдаг серби, хорват (Serbo-Croatian) хэлэнд (paper / бумага) гэсэн утгатай үгийг түрэг гаралтай осман түрэг хэлнээс зээлж авсан үгээр илэрхийлдэг байна⁹⁾.

Эртний түрэг хэл: qaγaz /kaγaz/ ~ kaγid (VII-XIII зуун)

> осман түрэг хэл: kyāghid /kæ:γud/ (XIV-XIX зууны сүүлч)

> серби, хорват хэл: кирилл hage (латин čage) [tɕa:ge] (paper)

(И.И.Толстой 1957, F.A.Bogadek 1944)

Үүнд: эртний түрэг: kaγid → осман түрэг: kyāghid > *čāgid (#kj- > #č-) → *čāgi (-d > -Ø / _ ·) → серби, хорват: [tɕa:ge] гэх зэрэг хувьссан байдлаас үзэхэд үгийн эхний гийгүүлэгч нь k- > kj- > č- гэсэн шат дамжин тагнайшсан нь XV-XVI зууны үед үүссэн байх гэж бид таамаглаж байна.

Энэхүү үгийг цуваа цагийн үүднээс үзэхэд эхний гийгүүлэгч k- > č-ийн тагнайших хоёр том урсгал байсан байх. 1-рт эртний түрэг хэлнээс XIII зуунаас өмнөх үед (бараг X-XII зууны сүүлч гэхэд тагнайших болсон болов уу) монгол хэлэнд үүссэн үзэгдэл, 2-рт эртний түрэг

хэлнээс авхуулаад осман түрэг хэлээр дамжин бараг XV-XVI зууны үед серби, хорват хэлэнд үүссэн үзэгдэл гэж дүгнэж болмоор байна.

7.1.2 Үгийн төгсгөлийн [-z] авианы хувьсал

Эртний түрэг хэлний *kaγaz* гэдэг үг XIII зуунаас өмнөх үед эртний монгол хэл (Ancient Mongolian)¹⁰-энд орохдоо үгийн төгсгөлийн [-z] авиа нь нэг бол [-s], эсвэл [-r] болох гэсэн хоёр янзаар хувьсан хөгжсөн байх гэж таамаглаж байна.

Түрэг хэлний үгийн төгсгөлд шүдний шүргэх [-z] авиа тохиолддог байхад монгол хэлэнд огт тохиолддоггүйгээс болж ойролцоо өөр авиагаар сольж хэлдэг байна.

1. Монгол хэлэнд [-s] авиагаар солигдсон үзэгдэл нэлээн харагдаж байна. Жишээ нь:

АТ. *bōz* “холст, бязь”, МqTur. *bōz* (124a, 217a) “уток, бязь”

> Мо. *bōs* (бөс) “fabric, cloth”

АТ. *teγiz* “море”, МqTur. *tengiz* (138a, 240a) ~ *tenggiz* (147b, 148a) “море”

> Мо. *tenggis* (тэнгис) “sea”

Нэг авиаг төсөөтэй өөр авиагаар солихыг англиар “Sound substitution” гэх бөгөөд дээрх жишээг бас энэхүү нэр томъёогоор тайлбарлаж болох байна.

2. Монгол хэлэнд [-r] авиагаар солигдсон үзэгдэл ч нэлээн харагдаж байна. Жишээ нь:

АТ. *ikkiz* “двония, близнецы” (← *ikki* “два, оба”)

> МqMo. *ikir* (195b) “двойни” → Мо. *ikere* (ихэр) “twins”

АТ. *boz* “серый”

> МqMo. *boza* (121b) “серый” → Мо. *boru* (бор) “gray, brown”

АТ. *boγaz* ~ *boγuz* “горло”

→ МqTur. *boγuzla-* (120a, 121a) “задушить, перерезать” (← *boγuz* “горло”)

> МqMo. *bo'ārla-* (*bo'ārlaba qonini*) (120a) “задушить”, *bo'ōrla-* (*bo'ōrlaba ingeni*) (121a), *bōrla-* (*bōrlaqsan qonin*) (123a) “перерезать”

→ Буриад: боорлохо “мучить, терзать”

Arabic *tamyiz* “distinction, difference”

> Persian: *tamiz* “1. distinction, difference, 2. clean, fresh”

> АТ. *čebär* “красивый” / Ottoman Turkish, Modern Turkish *temiz* “clean, pure”

> МqMo. *čeber* (131b) “красноречиво” → Мо. *čeber* (цэвэр) “clean, fresh”

Жич: Эртний түрэг хэлэнд *čebär* “красивый”, осман түрэг, орчин үеийн түрэг хэлэнд *temiz* “clean, pure” гэсэн хоёр янзаар гардаг нь их будилаантай юм. Харин бид эртний түрэг, монгол хоёр хэл нь ижил *čeber* гэсэн үгийг хэрэглэдгээс аль аль нь перс хэлний *tamiz* гэдгээс *tamiz* > *temiz* > *čeber* гэх зэргээр хувьсаж ирсэн байх гэж үзэж байна.

Үүнд: Persian *tamiz* → АТ. *čebär* / АМо. **čeber* → ММо. *čeber*, Мо. *čeber*

Энэхүү авианы хувьслыг хэл шинжлэлийн нэр томъёогоор “Rhotacism” гэх бөгөөд дуутай шүдний гийгүүлэгч [z], [d] нь голдуу хоёр эгшгийн хооронд юм уу, үгийн төгсгөлд орохдоо [r] болж хувьсдаг авианы үзэгдлийг хэлдэг байна¹¹).

Дээрх жишээнүүдээс дүгнэж үзвэл эртний түрэг хэлний үгийн төгсгөлд орсон [-z] авиа нь XIII зуунаас өмнөх үеийн эртний монгол хэлэнд орохдоо нэг бол [-s], эсвэл [-r] болж хувьсах бүрэн боломжтойг дурдаж болох байна.

7.1.3 Монгол хэлний нэрээс нэр үг бүтээх -sun/-sün дагаврын тухай

Орчин цагийн монгол хэлэнд нэрээс «адил төсөөтэй юм, холбогдол бүхий юм» (something of the same kind) гэсэн утга бүхий нэр үг бүтээх -с (α-сан) дагавар байдаг. Жишээлбэл:

адугуу (таван хошуу малын нэг “horses”) : адгуус (мал адгуус “animal”)
уур (уур нүдүүр “mortar”) : агуурс (эд агуурс “goods, wares”)
гөрөө (ан гөрөө “hunting”) : гөрөөс (өвсөн тэжээлт зэрлэг амьтад “antelope”)
хүй (эх үр хоёрын холбоо “navel string”) : хүйс (биеийн хонхор эрхтэн “navel”)
дараа (тээр садаа “hindrance”) : дараас (тээр дараа “burden”)
дайн (дайн байлдаан “war”) : дайсан (дайсагнаж байгаа этгээд “enemy”)

Дундад үеийн монгол хэлэнд энэхүү дагавар -sun / -sün нь одоо үеийнхээс илүү идэвхтэй байсан бөгөөд «ижил төрөл зүйл, ижил анги бүлэг» (something of the same group, collective) гэсэн утга санааг улам тодорхой илтгэж байсан бололтой.

Монголын нууц товчоо-ноос жишээ татан үзүүлбэл:

-Ө- (тэг) хэлбэр : -sun хэлбэр / Халх “утга нь”

а) *dayin* : *dayisun* / дайсан “enemy”

qubčan : *qubčasun* / хувцас “clothes”

qara'ul : *qara'ulsun* / харуул “sentry, guard”

б) — : *čaqdu'ulsun* / цагдуул “rear guard”

— : *moyilsun* / мойл “Bird cherry”

— : *ölirsün* / өрөл “Siberian apple”


Дээрх а)-ийн жишээнээс үзвэл *dayin* гэдэг үгийг тухайн үед “дайн байлдаан” гэсэн утгаар биш, ердөө “дайсан” гэсэн утгаар л хэрэглэж байсан (cf. М᠒᠓. *dain* (138a) “враг”) ба “хувцас” гэсэн утгаар бол -sun аваагүй хэлбэр болох *qubčan* гэдэг үгийг хэрэглэж байсан нь мэдэгдэж байна. Мөн б)-ийн жишээнээс үзвэл орчин цагийн монгол хэлэнд -sun аваагүй хэлбэртэй байсан тухайн үеийн байдал нь батлагдаагүй. Харин -sun авсан хэлбэр нь л батлагдаж байгааг харж болно.

Жич: 華夷訳語 (*Hua-yi yi-yu*) (1389) дээр монгол хэлний *нуруу* (Mo. *niruyun*) “back, ackbone” гэдгийг *nirisun* (你^ᠰ里孫) (1:24a6) «脊» гэж тэмдэглэжээ¹²⁾. Үүнийг А. Mostaert (1977:79), Мандах (1995:258) нар *nirisun* (你^ᠰ里孫) гэдгийн сүүлчийн 「孫(sun)」 үсгийг уг нь 「温(un)」 үсгээр бичих ёстой байснаа алджээ гэж үзсэний эцэст, *niri'un* (你^ᠰ里温) гэж залруулжээ. Бидний үзэхээр энэ нь тухайн үеийн үсгийн алдаа биш, дээрх МНТ. *qubčan* : *qubčasun* / хувцас “clothes” шиг үнэхээр *niri'un* : *nirisun* гэсэн хоёр хэлбэр байсан болов уу гэж таамаглаж байна.

Энэ байдлаас үзэхэд энэхүү -sun / -sün дагавар нь тухайн үед «төрөл зүйл, анги бүлэг» гэсэн утгыг илүү тодотгосон, монгол хэлний нэлээн идэвхтэй дагавар байсан гэж дүгнэж болох байна.

7.1.4 Эртний монгол хэлэн дэх цаас (rare) гэдэг үгийн хэлбэр ба хэрхэн хувьсаж хөгжсөн талаар

Дээр 7-р бүлгийн 7.1.1-д үгийн эхний гийгүүлэгч *k- > č-ийн тагнайшил, 7.1.2-т үгийн төгсгөлийн [-z] авианы хувьсал, 7.1.3-т монгол хэлний нэрээс нэр үг бүтээх -sun/-sün дагаврын учир гэсэн 3 дэд бүлэгт дурдсаныг энд хураангуйлбал: эртний түрэг хэлний А: каҗаз хэлбэрээс ХШ зуунаас өмнөх үеийн эртний монгол хэлэнд орохдоо 1-рт эхний гийгүүлэгч *k- нь č- болж тагнайшсан, 2-рт үгийн төгсгөлийн [-z] авиа нь нэг бол [-s], эсвэл [-r] болж хувьссан, 3-рт монгол хэлний нэрээс нэр үг бүтээдэг, нэлээн идэвхтэй -sun дагаврыг араас нь залгаж монголжуулсан (Mongolism) буюу монгол маягийн үг болгосон гэж таамагласан болно. Энэхүү үгийн авиа, хэлбэрийн хувьсал хөгжлийг бүдүүвчлэн харуулбал:



Бүдүүвч 1. “Цаас” гэдэг үгийн авиа, хэлбэрийн хувьсал

Өөрөөр хэлбэл эртний түрэг хэлний А: kayaz (paper) хэлбэрээс XIII зуунаас өмнөх үеийн эртний монгол хэлэнд орохдоо *čāyassun болон *čāyarsun гэсэн хоёр хэлбэр болж хувьссан бөгөөд энэ хоёр хэлбэрийг эртний монгол хэлний таамагласан хэлбэр (Reconstruction of Ancient Mongolian) гэж үзсэн болно.

Жич: Эртний түрэг хэлний тэргүүн үеийн эгшгийг *kāyaz гэж урт *ā* эгшгээр таамагласан нь даруй согд: kāyadā [ka:yaða:] > перс: kāghaz [ka:γaz] гэдэг үгийн тэргүүн үеийн урт эгшгээс үүдэлтэй болно. Тиймээс эртний монгол хэлний тэргүүн үеийн эгшгийг ч *čāyassun, *čāyarsun (*čayāssun, *čayārsun биш гэдгийг анхаарна уу!) гэж урт эгшгээр таамагласан болно.

7.1.4.1 Гийгүүлэгчийн нийлэмж *-ss-ийн хувьсал (*-ss- > -ls- > -s-)

Дээр эртний монгол хэлний таамагласан хоёр хэлбэрийн нэг нь *čāyassun бөгөөд үгийн дунд орсон гийгүүлэгчийн нийлэмж *-ss- нь яаж хувьсаж ирснийг тодруулъя.

Энэ авианы хувьсалд дээр 4-р бүлэгт дурдсан а) -l- хэлбэр, б) -Ø- (тэг) хэлбэр гэсэн хоёр янзын жишээнүүд хамаарагдах болно.

а) -l- хэлбэрийн жишээ: МНТ: ča'alsun, монгол (хүжү): qaalsi [tɕa:lsi], б) -Ø- хэлбэрийн жишээ: Мо. čayasun, халх: цаас(ан) гэх мэт.

Дээрхээс үзэхэд үгийн дунд орсон гийгүүлэгчийн нийлэмж нь *-ss- > -ls- > -s- гэх зэргээр хувьссан нь лавтай байна. Авиа зүйн хувьд 1-рт: *-ss- > -ls- болох үзэгдлийг “авиа ондооших ёс” (Dissimilation) (ижил хоёр авиа нэг дор орохоор нэг нь ижил бүтэх байрны өөр авиа болдог) гэсэн үзэгдлээр, 2-рт: -ls- > -s-¹³⁾ болох үзэгдлийг “авиа гээгдэх ёс” (Loss of sound) (ижил бүтэх байран дахь хоёр авианы нэг нь сугаран гээгддэг) гэсэн үзэгдлээр тус тус тайлбарлаж болох байна. Мөн үг нь -ls- хэлбэртэй ч бай, -s- хэлбэртэй ч бай, энэ хоёр хэлбэрийг нэгтгэн *монгол төрөл хэлнүүд дэх -S- хэлбэрт аялгуу* (The S-dialects of the Mongolic languages) гэж цаашид нэрлэе. Энэхүү бүлгийн аялгуу нь голдуу монгол төрөл хэлний төв аялгуунууд болно.

Энэхүү авианы хувьсал (-ls- > -s-)ыг Мо. čayasun (paper) гэдгээс гадна, Мо. mösün (мөс) “ice”, Мо. sösün (цөс) “gall, gall bladder” гэдгээс ч олж харж болно¹⁴⁾.

Мөн -l- гийгүүлэгчээр төгссөн үгэнд нэрээс нэр үг бүтээх -sun дагавар залгахад авиа зүйн хувьд -ls- > -s- болж хувьссан тохиолдол бас байна. Жишээ нь: Мо. aryal (аргал) “dried cow dung (used as fuel)” буюу (h)aryal > *aryalsun > aryasun¹⁵⁾ гэх мэт.


7.1.4.2 Гийгүүлэгчийн нийлэмж *-rs-ийн хувьсал (*-rs- > -rs-)

Дээр эртний монгол хэлний таамагласан хоёр хэлбэрийн нөгөө нь *čāyarsun бөгөөд үгийн дунд орсон гийгүүлэгчийн нийлэмж *-rs- нь өмнө дурдсан -ls- нийлэмжийг бодвол эхний гийгүүлэгч -r- гээгдэх нь тун цөөхөн, ер нь сайн хадгалагдах хандлагатай байна.

Ерөнхийд нь хэлэхэд -l-, -r- хоёр авиа нь бүтэх байр нь ижил хоёр өөр гийгүүлэгч боловч -l- (хажуугийн гийгүүлэгч) болон -s- (шүргэх гийгүүлэгч) авианы нийлэмж их хүчтэй тул -l- авиа гээгдэх боломж ихтэй байхад -r- (чичрэх гийгүүлэгч) болон -s- (шүргэх гийгүүлэгч) авианы нийлэмж сул буюу -r- авиа нь бие дааж харьцангуй тогтвортой байх тул гээгдэх боломж багатай гэж болно.

Энэ авианы хувьсалд дээр 4-р бүлэгт дурдсан с) -г- хэлбэртэй жишээнүүд хамаарагдах болно. Үүнийг *монгол төрөл хэлнүүд дэх -R- хэлбэрт аялгуу* (The R-dialects of the Mongolic languages) гэж ялгаж нэрлэе. Энэхүү бүлгийн аялгуу нь монгол төрөл хэлний хойд зүгийн аялгуунууд болно.

Энэхүү авианы хувьсал нь *-rs- > -rs- гэж гарах нь олонтоо тохиолддог ч, хааяа нэг цаашид *-rs- > -rs- > -s- гэх зэргээр -r- авиа гээгдэн хувьссан тохиолдол байна¹⁶⁾. Дээр 7.1.4.1, 7.1.4.2-т дурдсаныг хураангуйлж бүдүүвчээр үзүүлбэл:



Бүдүүвч 2. “Цаас” гэдэг үгийн авианы хувьслын тайлбар

7.1.5 “Tur. -z > Mo. -r + -sun” гэсэн саналыг дэмжих нь

Дээр 7.1.4-г дурдсанаар цаас гэдэг үгийн эртний монгол хэлний хэлбэрийг таамаглахдаа авиа зүйн хувьд эртний түрэг хэлний үгийн төгсгөлийн [-z] авиа нь нэг бол [-s] (*Sound substitution*), эсвэл [-r] (*Rhotacism*) болж хувьссан, бас үг зүйн хувьд Монгол хэлний нэрээс нэр үг бүтээх -sun дагаврыг араас нь залгаж монголжуулсан (*Mongolism*) гэсэн утгатай саналыг дэвшүүлсэн билээ. Энд энэ саналыг дэмжихээр өөр бас нэг жишээ татъя¹⁷⁾.

AT. *müñüz* (~ *mügüz* ~ *müyüz*) “рог (животного)”

→ MqTur. *müñgüz* (131b, 150a, 378a) (рог) > Mo. **mögür-sün* → *mögersün* (мөгөөрс) “хрящ; хрящевой”

Монгол хэлний мөгөөрс “cartilage” гэдэг үгийн тухайд дундад үеийн монгол хэлэнд огт батлагдаагүй ч гэсэн үндсэндээ цаас гэдэг үгтэй адил шугамаар хувьсаж ирсэн байх гэж таамаглаж байна. Үүнд: Эртний түрэг хэлний *müñüz* (~ *mügüz* ~ *müyüz*) гэх үгийн төгсгөлийн [-z] авиа нь XIII зуунаас өмнөх үеийн эртний монгол хэлэнд орохдоо [-r] болж хувьссан (үүнийг *Rhotacism* гэнэ) бөгөөд араас нь монгол хэлний -sun дагаврыг залгаж бүтсэн (үүнийг *Mongolism* гэнэ) гэсэн утгатай. Нэг анхаарууштай зүйл бол утгын хувьд AT-д “рог (животного)” ((амьтны) эвэр) гэсэн утгатай байснаа Mo. (AMo. ч мөн ялгаагүй байсан байх)-д утга нь “horn” (эвэр) → “hornlike” (эвэр шиг, эвэрлэг) → “cartilage” (мөгөөрс) гэх мэтээр бага зэрэг өөрчлөгдсөн бололтой. Энэ үгийн бүтэц нь монгол хэлний цаас гэдэг үгийн гарал, хөгжлийг судлахад их чухал баримт болж чадна гэж найдаж байна.

7.2 Эртний түрэг хэлний B: kegde хэлбэрээс хувьсах нь

Дээр 7.1-д VII-XIII зууны үеийн эртний түрэг хэлний A: kaγaz хэлбэр нь XIII зуунаас өмнөх үед эртний монгол хэлэнд орохдоо яаж хувьсаж хөгжиж ирсэн тухай хэлний авиа, хэлбэр болон нутгийн аялгууны тархцын үүднээс нягтлан судалж, зохих хэжээгээр тодруулсан билээ.


Энэ бүлэгт IX-XIV зууны үеийн эртний уйгур хэл (Ancient Uighur)-ний B: kegde хэлбэр нь эртний монгол хэлээр дамжин дундад үеийн монгол хэл болон монгол төрөл хэлнүүдэд яаж орж ирсэн тухай сайн судлах шаардлагатай байна.

Нутгийн аялгууны тархцын үүднээс хэлэхэд A: kaγaz хэлбэр нь монгол төрөл хэлний төв болон хойд зүгийн аялгуунуудтай, B: kegde хэлбэр нь монгол төрөл хэлний өмнө зүгийн аялгуунуудтай тус тус холбогдож байгааг урьдчилан мэдэгдье.

Эртний уйгур хэлэнд AUig. kegde (paper) гэж гардаг (Jens Wilkens 2021) бөгөөд энэхүү үг нь дундад үеийн монгол хэл болон монгол төрөл хэлнүүдэд хэрхэн гарч байгааг эхлээд үзүүлье. Үүнд:

『事林広記』 (*Shilin Guangji*) 卷8 「蒙古訳語」 (*Menggu yi-yu*) (1325)
 怯里歹 /kerdei/ 《紙》 (298) (< AMo. *kegde < AUig. kegde)
 cf. 『華夷訳語』 (*Hua-yi yi-yu*) (1389): 察阿_勳孫 /ca'alsun/ 《紙》 (1:10b8)

Жич: Энэ хятад үсэг 怯里歹-ийн дуудлагыг L.Ligeti (1990) /kekdei/, Мандах (1995) /kerdai/ гэж уншжээ. Харин тус сурвалж бичигт ер нь “дэвсгэр үсэг” (үеийн төгсгөлд ордог гийгүүлэгч) -y/-g авиаг тэмдэглэлгүй орхисон юм (Жишээ нь: Мо. quyaу (Kh. хуяг)-ийг 忽耶 *quya* 《甲》 гэж тэмдэглэжээ). Тиймээс ч 黒 (-k/-q) гэж бичих ёстойг андуураад 里 (-li/-ri) гэдэг үсгээр бичсэн гэж байх ёсгүй тул /kekdei/ гэж унших боломжгүй бөгөөд AUig. *kegde* хэлбэрээс үндэслэн, мөн 里 (-li/-ri) дуудлага болон эгшиг зохицох ёсыг дагаж, тухайн үеийн дуудлагыг нь /kerdei/ гэж бид үзлээ.



Зураг 2. Монгол төрөл хэлнүүд дэх *kegde* үгийн тархац (+ Идэвхтэй, Δ Идэвхгүй)

эртний түрэг хэл: *kegde*, *kegede* (бумага) (VII-XIII зууны үе)

эртний уйгур хэл: *kegde* (paper) (IX- XIV зуун)

→ баруун ёгор хэл: *kedie* (Хятадын Ганьсу мужийн түрэг гаралтай хэл)

Монгол төрөл хэлнүүдийн бао-ань, дуншаан, канжя зэрэг гурван хэлэнд *цаас* (paper) гэсэн утгаар В: *kegde* хэлбэрийг хэрэглэдэг байна.

Жич: эртний уйгур хэл нь одоогийн Шинжаан Уйгурын Өөртөө Засах Орны зүүн хэсэгт (Турфан, Хами) болон Ганьсу мужийн баруун хэсэгт голдуу тархсан болохоор тэр нь монгол төрөл хэлний Өмнө зүгийн аялгуунуудад багтдаг тэр хавийн гурван хэлэнд ихэд нөлөөлсөн байх талтай юм.

бао-ань: [gədge] (-dg- (Metathesis) ← -gd- < AMo. *kegde)

дуншаан: [giədzia] (-Ø- ← -g· (Loss), -dzia ← -de (Palatalization) < AMo. *kegde)

канжя: [gebde] ~ [gibde] (-b ~ -g (Alternation) < AMo. *kegde)

Эртний уйгур хэл нь түрэг төрөл хэлнүүдэд багтдаг ба IX-XIV зуун хүртэл биеэ даасан хэл байсан бөгөөд XIV зууны эхэн үеийн хятад-монгол хэлний сурвалж бичигт нэгэнт 怯里歹 /kerdei/ гэж гарч байгаагаас үзэхэд ер нь XIII зуунаас өмнөх үеийн эртний монгол хэлэнд ч **kegde* гэдэг шиг хэлбэрээр илрэн гарч байсан болов уу гэж таамаглаж байна.

Дээрх байдлаас үзэхэд эртний уйгур хэлнээс орсон (үнэндээ ATur. → AUig. > *AMo. → MMo. гэсэн замаар орсон) В: *kegde* хэлбэр нь XIV зууны эхэн үед “paper” гэсэн утгаар хэрэглэгдэж байсан нь тодорхой байна.

Бас XIII зууны эхээс дунд үед зохиогдсон *Монголын нууц товчоо*, 華夷訳語 (*Hua-yi yi-yi*) (1389) болон XIV зууны үеийн *Мукаддимат ал-Адаб* зэрэгт бүгд ᠑a'alsun, ᠑ālsun (энэ нь эртний түрэг хэлний А: kaγaz хэлбэрээс хувьсаж ирсэн) гэх зэргээр гарч байгаагаас үзвэл наанадаж XIV зууны эхэн үе хүртэл “paper” гэсэн утгаар /kegde/ болон /᠑a'alsun/ гэдэг хоёр хэлбэрийг хамт хэрэглэж байсан байна. Энэ хоёр үгийн ялгаа нь: /kegde/ хэлбэрийг зөвхөн бичгийн хүмүүсийн дунд албан ёсны хэлэнд хэрэглэдэг үг байсан байхад, /᠑a'alsun/ хэлбэрийг энгийн хүмүүсийн дунд ер нь хар ярианы хэлэнд хэрэглэдэг өдөр тутмын үг байсан болов уу гэж таамаглаж байна.

7.2.1 В: kegde хэлбэр дэх монгол хэлний утгын хувьсал

В: kegde хэлбэр нь монгол төрөл хэлнүүдэд гол байр суурь эзэлдэг монгол хэлэнд хэрхэн илэрч байгааг ялангуяа XVIII зуунаас хойших монгол-манж-хятад хэлний толь бичгүүдээс нягтлан үзэж болох байна. Үүнд: Мо. kegde гэдгийг доорх байдлаар тэмдэглэжээ¹⁸⁾.

『御製滿蒙合璧清文艦』 (Han-i araha manju gisun-i buleku bithe) (1717):

nekei ilgin-dür alta naγaldyuluγsan-i inu kegde kememüi.

『御製滿珠蒙古漢字三合切音清文艦』 (Han-i araha manju monggo nikan hergen ilan hacin-i mudan acaha buleku bithe) (1780): Ch. 羊皮金 / Ma. gina

『御製五体清文鑑』 (Han-i araha sunja hacin-i hergen kamciha manju gisun-i buleku bithe) (XVIII зууны сүүлч): Ma. gina / Ch. 羊皮金 [貨財類 (Ed tawar-un jüil)]

『蒙文倒綱』 (*Mengwen Daogang*) (1851): Ch. 羊皮金 / Ma. gina

『蒙文總彙』 (*Mengwen Zonghui*) (1891): Ch. 羊皮金 / Ma. gina

Үүнээс Мо. kegde гэдэг үгийг “*нэхий илгэнд алт наалдуулсан юм*” буюу англиар “*sheepskin decorated with gold leaf*” гэсэн утгатай гэж ойлгож болно.

Бас XIX зуунаас хойших монгол бичгийн хэлний гол толь бичигт:

Ковалевский (1844): gegde / *розь позолоченной бумаги* (алтан хуудасны нэг төрөл)

Голстунский (1895): kegde / *листовое золото, наклеиваемое на сафьян, поталь* (алтан хуудас, илгэнд наасан алтан хуудас)

Lessing (1960): gegde (—) / n. *kind of gilt paper*

Цэвэл (1966): хэгд / алтан өнгөөр хээ угалз тавьж хийсэн илэг нэхий

『蒙漢詞彙』 (1990): kegde [xəgd] / 貼金羊皮祆 (parchment with gold leaf)

Энэ байдлаас үзэхэд XVIII, XIX зууны үед зохиогдсон манж-монгол хэлний толь бичгийн “Мо. kegde / Ma. gina / Ch. 羊皮金” гэсэн тайлбар нь XIX, XX зуунаас хойш гарсан монгол бичгийн хэлний толь бичгийн тайлбарт их нөлөө үзүүлсэн нь лавтай байна. Гэвч энэхүү Мо. kegde (хэгд) гэдэг нь халх, өвөр монгол зэрэг монгол хэлэнд одоо хуучирсан үг болон бүр мартагджээ. Харин бусад Халимаг, Буриад зэрэг хэлэнд ер ороогүй бололтой.

Дүгнэж хэлэхэд Ch. 羊皮金¹⁹⁾ (Мо. kegde / Ma. gina) гэдэг нь ер нь XVIII зууны Чин улсын үед өргөн дэлгэрсэн гоёл чимэглэл, урлагийн бүтээлийн нэгэн чухал арга хэлбэр байсан бөгөөд “*хонины элдсэн нимгэн арьс буюу илгэнд алтан хуудсыг наасан зүйл*”-ийг хэлдэг байсан үг болно.

Энэхүү үгийн утгын хувьслын тухайд ATur. kegde (paper) → AUig. kegde (id.) > *AMo. → MMo. kegde (怯里歹/kerdei/ (1325)) (id.) хүртэл уг утгыг нь сайн хадгалж байснаа XVIII зууны эхэн үе гэхэд “*илгэнд алтан хуудсыг наасан юм*” гэсэн утгатай болж утга нь явцуурсан буюу англиар “*Narrowing (specialization, or restriction of meaning)*” гэж болох юм. Үүнд:

ATur. → AUig. > *AMo. → MMo. —————→ XVIII зууны эхэн үе	
“paper”	“paper” —————→ “sheepskin decorated with gold leaf”
a thin material for writing	sheepskin (parchment) + gold leaf
	(Үндсэн гол утга) (Нэмэлт утга)

Бүдүүвч 3. “kegde” хэлбэрийн утгын хувьсал

Өөрөөр хэлбэл “*paper*” болон түүний шилжсэн утга болох “*sheepskin (parchment)*”²⁰⁾ хоёрын нийтлэг утга нь “*бичих зориулалттай материал*”-д оршиж байгаа бөгөөд түүн дээр “*gold leaf*” гэх чимэглэлийн санааг нэмсэн бололтой.

Бас соёлын харилцааны үүднээс авч үзвэл, Мо. *kegde* хэмээх үг нь XVIII зуунаас хойш хоёр чиглэлийн соёлын илэрхийлэл болон хэрэглэгдэж иржээ. Нэг талаас нь харахад “*нэхий илэг*” ашигладаг уламжлалт монгол мал аж ахуйн соёлыг тусгасан бол нөгөө талаас хятад, перс зэрэг гадаадын соёлд хэрэглэгддэг “*алтан хуудас*”-ны уламжлалыг шингээсэн утга агуулгатай болсон байна.

Жич: Зарим монгол бичгийн хэлний тольд Мо. *kigde* (хигд) “*金粉*” (алтны нунтаг) гэж тэмдэглэсэн нь авиа зүйн хувьд авч үзвэл энэхүү Мо. *kegde* гэдгийн эгшиг *e~i* сэлгэж бүтсэн үг бөгөөд утгын хувьд Мо. *kegde*-ийн нэмэлт утга болох “*gold leaf (алтан хуудас)*”-тай нягт холбоотой буй заа. Үүнд:

Мо. *kegde* “*paper*” → “*sheepskin*” (илэг) + “*gold leaf*” (алтан хуудас)
> Мо. *kigde* (хигд) “*gold dust*” (алтны нунтаг)

7.2.2 Кидан хэлний “*paper*” гэдэг үгийг таамаглах нь

Кидан хэл (契丹語) нь X-XII зууны үед одоогийн Хятадын зүүн хойд хэсгээр нутагладаг байсан Киданчуудын хэл бөгөөд өдгөө бол мөхсөн хэлэнд тооцогддог. Бас монгол төрөл хэлнүүдийн эх үүсэл болох өвөг монгол хэл (Proto-Mongolic languages)-тэй гарлын холбоотой хэлнүүд буюу Para-Mongolic Languages-д багтдаг сяньби хэл (鮮卑語), жужан хэл (柔然語)-тэй ч гарлын холбоотой байсан хэл юм.

916 онд Елюй Абаожи (耶律 阿保機) нь Кидан Улс (Ляо Улс)-ыг байгуулж, 920 онд хятад ханзнаас гаралтай, утга заах үсэг болох “кидан их үсэг” зохиосон байхад 924-925 оны үед дүү Елюй Диэла (耶律 迭剌) нь эртний уйгур хэл (Ancient Uighur, IX-XIV зууны үеийн) бичгээс гаралтай, авиа тэмдэглэх үсэг болох “кидан бага үсэг” зохиосон түүхтэй.

Өөрөөр хэлбэл кидан хэл нь их, бага үсэг гэсэн хоёр төрлийн үсэгтэй. Бага үсэг нь их үсгээс илүү судлагдсан ч одоо ч бүрэн тайлагдаагүй гэж болно.

Эртний уйгур хэл бичгээс санаа авч кидан хэлний бага үсгийг зохиосон тул түүнтэй зэрэгцэн зохих тооны уйгур үг (эртний уйгур үг) нь Кидан хэлэнд орсон нь гарцаагүй юм. Жишээ нь:

1. Зээлдсэн үгийн А хэлбэр: (AUig. + > Kitan: + / Мо. +)

Эртний уйгур хэлнээс кидан, монгол хэлний хоёуланд нь орсон нь:

AUig. *xaγan* ~ *qayan* “Kaiser” > Kitan: *qā* 可汗 / Мо. *qayan* “king, khan”

AUig. *ordu* “Palast, Schloss” > Kitan: *ordū* 行宮 / Мо. *ordu* “palace”

AUig. *bol-* “werden, sein” > Kitan: *bōl-* / Мо. *bol-* “to become, to be”

AUig. *užik* ~ *üžik* “Buchstabe” > Kitan: *usgi* 字 / Мо. *üsüg* “letter of alphabet”

2. Зээлдсэн үгийн В хэлбэр: (AUig. + > Kitan: + / Мо. —)

Эртний уйгур хэлнээс кидан хэлэнд орж, монгол хэлэнд нь ороогүй нь:

AUig. *ay* “Mond, Monat” > Kitan: *ay* 年 “year” / Мо. —

(cf. Kitan: *sayr* “month, moon” / Мо. *sara* “month, moon”)

AUig. *tegin* “Prinz” > Kitan: *tīyin* 惕隱 (特勤) “Tegin” / Мо. —

Одоогоор кидан хэлэнд “*paper*” гэдэг үг ямар хэлбэртэй байсан нь огт батлагдаагүй боловч дээрх байдлаас үзэхэд:

1-рт: “үсэг” гэдэг үгтэй хамт “цаас” гэдэг үг ч мөн эртний уйгур хэлнээс кидан хэлэнд орсон байх боломжтой гэж төсөөлж байна.

2-рт: Эртний уйгур хэлнээс кидан хэлэнд орсон гэж үзвэл тэр нь лав AUig. kegde (paper) хэлбэрээс орсон байх гэж үзэж байна. Ер нь кидан, монгол хэлний үгийн эхний гийгүүлэгчийн хооронд Мо. *k-* : Kitan *č-* / #_e (Front Vowel) гэсэн авианы тохиролцоо харагдаж байна. Жишээ нь: (Ōtake Masami 2016a, b)

Мо. *ki-* (хий-) : Kitan *čē-* [ʃə:-] (to do)

ММо. *ki'ed* (Мо. *kiged*) : Kitan *čēj* [ʃə:dʒ] (and so on, etc.)

Мо. *ken* (хэн) : Kitan *čē* [ʃə:] (who)

Энэ байдлаас үзэхэд үгийн эхний гийгүүлэгч *k-* нь хэлний урдуурх эгшиг *e-*ийн өмнө орохдоо кидан хэлэнд *k-* > *kj-* > *č-* гэх зэргээр тагнайших боломжтой тул AUig. kegde (paper) хэлбэрээс AUig. kegde > Kitan **čēgde* → **čēged* [ʃə:gəd] болж хувьссан буюу кидан үгийн хэлбэрийг **čēged* [ʃə:gəd] “paper” байсан болов уу гэж таамаглаж байна.

3-рт: 1344 онд зохиогдсон *Ляо улсын судар* (遼史)-ын 32-р дэвтэрт “VIII зууны үед Кидан өөрөө 20 аймагтай байсан бөгөөд тэдгээрийн нэг нь 楮特 байсан” тухай тэмдэглэжээ. 楮特 гэдэг ханзны эхний үсэг 楮 нь «1. (модны хальс нь цаасны түүхий эд болох ургамал) *үст дургана*, 2. (эртний бичгийн хэл) *цаас*» гэсэн утгатай бөгөөд VIII зууны үеийн 楮特 гэдэг ханзны дуудлагыг /tjodək/~čodək/ байсан гэж үзээд, тухайн үеийн кидан дуудлагыг /*čōdək/ гэж үзжээ.

Дээрх 2-рт: Кидан үгийг **čēged* [ʃə:gəd] “paper”, 3-рт: *цаас* гэсэн утгыг агуулсан 楮特 аймгийн нэрийг /*čōdək/ гэж таамагласныг авиа зүйн хувьд авч үзвэл AUig. kegde (paper) > Kitan **čēgde* → **čēged* [ʃə:gəd] (paper) → **čēdeg* [ʃə:dæg] (Metathesis) → **čōdək* (Киданы аймгийн нэр “楮特”) гэх мэтээр хувьсаж ирсэн байх гэж бид таамаглаж байна. Бодвол 楮特 аймгийн хүмүүс цаас үйлдвэрлэх, эсвэл бичиг цаастай холбоотой ажил эрхэлдэг байсан ч байж болох юм.

Энэ бүлэгт дурдсаныг хураангуйлж хэлэхэд X-XII зууны хооронд ярьж хэрэглэдэг байсан кидан хэлний “paper” гэсэн үгийг **čēged* [ʃə:gəd] гэж бид таамагласан бөгөөд энэхүү үгийн эхний гийгүүлэгч нь нэгэнт **k-* > *kj-* > *č-* болон тагнайшсан байх боломж ихтэйг харуулж байна.

8. Мо. čayasan / kegde (paper) хэмээх үгийн түүхийг судлах нь


Дээр 3-р бүлгээс 7-р бүлэгт дурдсаныг хураангуйлбал: Хятад хэлний гаралтай үг нь согд хэл болон перс хэлээр дамжин, хятад: 穀紙 /kuk-teie/ > **kōgza* > согд: /kāyadā/ ~ перс: *kāghaz* > эртний түрэг хэлний 6 янзын хэлбэрээс А: kaγaz / В: kegde хэлбэр (paper) > Монгол: А: цаас / В: хэгд гэсэн хоёр замаар хувьсаж ирснийг тодруулсан билээ.

А: kaγaz хэлбэрээс үгийн төгсгөлийн [-z] авиа нь нэг бол [-s], эсвэл [-r] гэсэн 2 янзаар хувьссан байдлаас эртний монгол хэлний хэлбэрийг **čāγassun* болон **čāγarsun* гэж таамагласан болно.

Эхний **čāγassun* хэлбэрээс гийгүүлэгчийн нийлэмж нь **-ss-* > *-ls-* > *-s-* зэрэг хувьссан байдлаас *-S-* хэлбэрт аялгуу, бас сүүлчийн **čāγarsun* хэлбэрээс **-rs-* > *-rs-* зэрэг хөгжсөн байдлаас *-R-* хэлбэрт аялгуу гэж хоёр хуваагдах ба үүнийг монгол төрөл хэлний төв аялгуу болон хойд зүгийн аялгуу гэж тус тус хэлж болох юм.

В: kegde хэлбэр нь эртний уйгур хэлнээс эртний монгол хэлээр дамжин дундад үеийн монгол хэлэнд орсон бөгөөд тэр нь одоогийн бао-ань, дуншаан, канжя гурван хэлэнд бүрэн хадгалагджээ. Үүнийг монгол төрөл хэлний өмнө зүгийн аялгуу гэж бас болно. Харин одоо үеийн монгол хэлэнд энэхүү үгийн ул мөр байгаа ч бараг мартагдсан үг болсон бөгөөд утгын хувьд “paper” гэсэн уг утгаас “sheepskin decorated with gold leaf” болон утга нь явцуурсан байна. Мөн кидан хэлэнд В: kegde хэлбэрээс **čēged* [ʃə:gəd] гэж таамагласан болно.

Энэхүү хоёр үгийн хувьсал хөгжлийн түүхийг хөөж үзвэл хятад гаралтай үг нь согд, перс хэлээр дамжин эртний түрэг хэлнээс эртний монгол хэлэнд орсон боломж байхад, нөгөөтэйгүүр эртний уйгур хэлнээс эртний монгол хэлээр дамжин монгол төрөл хэлэнд орсон байх боломжтой. Ялангуяа үгийн эхний гийгүүлэгч *k-ийн хувьсал буюу *k- > kj- > ħ-ийн тагнайшсан явцыг хэлний тархцын бүдүүвч зургаар доорх маягаар үзүүлж болох юм.



Зураг 3. Үгийн эхний гийгүүлэгч *k- гийн хувьсал *k- > kj- > ħ- ба тархац

9. Монгол хэлний qayudasun (хуудас) (sheet of paper) гэдэг үгийн учир

Эрт үед модноос цаас хийх үйл явц дараах дарааллаар явагддаг байжээ²¹. 1. Модны холтос, хальсыг хуудах, 2. Хуулсан эдийг буцалгах, 3. Буцалгасны дараа нухаш болтол нь нухах, 4. Гарсан нухшийг шүүх, 5. Шүүсэн нухшийг нимгэн түрхэж хатаах. Өөрөөр хэлбэл *модны холтос, хальсыг хуулж*, боловруулсны эцэст цаас бэлэн болдог байсан гэсэн үг юм.

9.1 Монгол бичгийн хэлний qayudasun хэлбэрийн үгийн гарал

Эхлээд монгол хэлний хуудас гэдэг үгийг хэлбэр болон утгынх нь талаар авч үзье. монгол бичгийн хэл (Schmidt, Ковалевский, Lessing): qayudasun “sheet of paper; page” *The Rasulid Hexaglot* (XIV зууны үе): quldasun (204c27) “the thin bark of a tree” (*модны нимгэн хальс*) (Peter B. Golden 2000)
тод бичиг: xuudasun “лист; страница”
халх: хуудас (хуудсан) [xu:das] “sheet of paper; page”
буриад: хуудaha(н) [xu:daɦa(n)] “лист (бумажный); страница”
хуучин барга: [xu:das] 頁 “page”
хамниган (орос): хуудасу(н) [xu:dasu(n)], хуудаса(н) [xu:dasa(n)] “лист; страница”
халимаг: хуудс [xu:ds] “лист (бумаги)”

Хэлбэрийн хувьд авч үзвэл Мо. qayudasun (хуудас) гэдэг үг нь Мо. qayul- (хуул-) “vt. peel off, skin” (*арьс, хальс зэргийг өвчиж авах, салгаж авах*) гэдэг үйл үгийн үүсмэл үг (-dasun гэдэг нь үйлээс нэр үг бүтээх, “үйлийн үр дүнд бий болсон юм” гэсэн утгатай дагавар) мөн бөгөөд энэхүү нэр үгийн анхны утга нь “something that was peeled off” (*ямар нэгэн юмнаас өвчиж авсан юм, салгаж авсан юм*) гэсэндүү утгатай байсан гэж бид үзэж байна. Үүнд: Мо. qayul- (хуул-) “peel off” > qayul-dasun (V-N suffix) → qa’ūldasun → qūldasun (-l- > -Ø- / #CV_·d) → qūdasun (хуудас)

Утгын хувьд авч үзвэл “модны холтос, хальс”-ыг хуулж аваад, түүгээр “цаас” хийдэг байсан болохоор доорх мэтээр утгын хувьслыг төсөөлж болох байна. Үүнд:

хуу “off” (ховх) > хуул- “peel off” (салгаж авах) > хуулдас “something that was peeled off (from the tree)” → “tree bark” → хуудас “sheet of paper” → “page”

XIV зууны үеийн “Расулидийн зургаан хэлний толь бичиг”-г энэхүү үгийн хэлбэр нь quldasun гэж хуучин -l- хэлбэртэй гардаг бөгөөд бас утга нь ч “the thin bark of a tree” (*модны нимгэн хальс*) гэсэн анхны утгаар нь гардаг зэрэг нь маш чухал байна.

Үйл үгийн төгсгөлийн -l- гийгүүлэгчийн дараа үйлээс нэр үг бүтээх Мо. -dasun (-дас⁴) дагавар ороход ер нь -l- нь гээгдэж, -**ld-** > -**d-** болох нь олонтоо харагдаж байгааг энд дурдууштай байна. Үүнийг дээр 7.1.4.1-д дурдсанаар гийгүүлэгчийн нийлэмж -**ls-** > -**s-** болох авианы үзэгдэлтэй адитган тайлбарлаж болох болов уу. Жишээ нь:

өө (roughness) > өөлө- (to trim) > *өөл-дөс > өөдөс (scraps, rags)

Энэхүү үгийн гарлын тухайд авч үзвэл:

1-рт: хуу “off” (хуу татах = ховх татах) гэдэг “*Цаашид дагавар залгаж болдог идэвхгүй язгуур*” (unproductive variable root) (Шиотани Шигэки 2009:187) буюу “дайвар үг”-ээс тусах үйл үг хуул- “vi. peel off, skin”, түүнээс нэр үг хуулдас, цаашлаад хуудас “sheet of paper; page”, бас эс тусах үйл үг хуур- “vi. come off, be taken off” гэх зэрэг үг үүссэнээр²²) *word family* буюу нэг язгуурт үгсийг бүрдүүлдэг.

2-рт: Энэхүү төрлийн идэвхгүй язгуур хуу “off” (хуу татахын) нь монгол хэлний өвөрмөц дайвар үг²³) бөгөөд хага “apart” > хуга “off, apart” > хуу “off” гэх мэт эгшиг сэлгэсэнээр нарийн утга санааг ялган илэрхийлж, нэг ёсны бас л ижил үгсийн бүлгийг сайхан бүрдүүлж өгдөг.

Дээрх хоёр баримтаас үндэслэн энэхүү хуудас (sheet of paper; page) гэдэг үгийг харь үг биш, ерөөсөө монгол гаралтай үг гэж бид дүгнэж байна.

9.2 Манж бичгийн хэлний hoosān гэдэг үгийн гарал

Алтайн язгуурын хэлнүүдийн үүднээс үзэхэд “paper” гэдэг үгийг манж-түнгүс хэлний бүлэгт багтдаг зүрчид, манж бичгийн хэл, мөн хятадын саньцзязы (三家子), сибэ, хэжэн зэрэг хэлнүүдэд доорх байдлаар хэлдэг байна.

Зүрчид: 好沙 xausa [xaʉʃa] (564), манж бичгийн хэл: hoosān [xɔ:ʃan]²⁴)

Саньцзязы: [xɔaʃun], Сибэ: hoxin [xɔɛin], Хэжэн: [xaɛin]

Ер нь нэг хэлнээс нөгөө хэлэнд үг зээлэгдэн орсон эсэхийн тухай бид авч үзэхдээ 1-рт: Нэг язгуурт үгс (word family) бүрдүүлж чадаж байгаа эсэх, 2-рт: Үг бүтээдэг үеийн тоо багасах эсэх (үгийг хялбарчлах эсэх) гэсэн хоёр шалгуурыг баримталж байна.

1-рт: Монгол хэлний хуудас гэдэг үг нь хуу, хуул-, хуулдас, хуудас, хуур- гэсэн нэг язгуурт үгсийн нэг бүрэлдэхүүн нь болж байхад, манж-түнгүс хэлний бүлэгт дээрх үгс нь нэг язгуурт үгс бүрдүүлж огт чадахгүй байна.

2-рт: Үг бүтээдэг үеийн тооны тухайд Мо. qayudasun (< qa-yu-da-sun) нь 4 үеэр бүтсэн байхад Ма. хоошан (< хоо-шан) болон бусад манж-түнгүс хэлэнд 2 үеэр бүтсэн байна.

Дээрх хоёр шалгуурыг үндэс болгож үзвэл монгол хэлний qayudasun хэлбэрээс манж-түнгүс хэлний бүлгийн хэлнүүдэд зээлэгдэн орсон байх магадлалтай гэж үзэж байна. Үүнд:

Мо. qayudasun “sheet of paper” ← *qayul-dasun²⁵) (← АМо. *qayul-dal-sun)

> *qau-**da**-sun (-da->-Ø- / The loss of the syllable -da- within a word)

> *xausun (q- > x- / #_V...·)

> xausin (Hezhen) > xausān (Sanjiazi) > xausa (Jurchen)

> хоошан (Ma.) > хошан (Sibe)

Жич: Монгол бичгийн хэлний 3-аас дээш үет үг (Polysyllabic word) нь үгийнхээ дунд /-dV-/ үетэй бол манж бичгийн хэлэнд орохдоо тэрхүү /-dV-/ үе нь гээгдэх үзэгдэл мэр сэр харагдаж байна. Жишээ нь:

Мо. nidurya (нударга) “fist” (ni-dur-ya нь 3 үетэй) (cf. nidur- (нудар-) “to nudge”)

> *nu-du-rgan (-du- > -Ø-)

> *nurgan (-rg- > -j-²⁶) болж хувьсах дүрэмтэй)

> Ма. nujan “fist” (nu-jan нь 2 үетэй)

Түүнээс гадна, түрэг төрөл хэлний нэг болох Чуваш хэлэнд “бумага” гэдгийг хут [xuot] гэдэг бөгөөд энэ нь бусад түрэг төрөл хэлнүүдээс эрс ялгаатай байгаа нь тун сонирхолтой байна. Энэ үгийг бид монгол хэлний qayudasun (хуудас) (sheet of paper) гэдгээс Чуваш хэлэнд орсон байх боломж их гэж үзэж байна. Аль эсвэл гарлын хувьд холбоотой байсан байж магадгүй юм.

10. Дүгнэлт

Тус өгүүлэлдээ монгол хэлний цаас (paper) гэдэг үгийн гарал, бүтцийн хувьсал хөгжлийг тус үгийн авиа, хэлбэр, утга болон Алтайн язгуурын хэлнүүдийн үүднээс тодруулахын зэрэгцээ монгол хэлний хуудас (sheet of paper; page) гэдэг үгийн гарлыг ч бас хөөж үзлээ.

Судалгааны дүнд дараах зүйлийг тодруулсан болно.

1. Монгол хэлний цаас (paper) гэдэг үг нь монгол хэлний уугуул үг биш, утгаа хятад гаралтай үг мөн. Тус үг нь согд хэл болон перс хэлээр дамжин монгол хэлэнд хоёр өөр замаар, өөрөөр хэлбэл а. Эртний түрэг хэлний А: kayaz хэлбэрээс цаас, б. Эртний уйгур хэлний В: kegde хэлбэрээс хэгд гэсэн хэлбэрээр тус тус хувьсан иржээ.

2. Эртний түрэг хэлнээс XIII зуунаас өмнөх үеийн эртний монгол хэлэнд орохдоо а. Үгийн эхний гийгүүлэгч *k- > č- гийн тагнайшил, б. Үгийн төгсгөлийн [-z] авианы хувьсал, с. Монгол хэлний нэрээс нэр үг бүтээх -sun дагаврыг араас нь залгах гэх зэрэг 3 янзын авиа болон хэлбэрийн өөрчлөлт орж монголжсон болно.

3. Ялангуяа А: kayaz хэлбэрээс үгийн төгсгөлийн [-z] авиа нь нэг бол [-s], эсвэл [-r] гэсэн 2 янзаар хувьсан байдлаас эртний монгол хэлний хэлбэрийг *čayassun болон *čayarsun гэж таамагласан болно. Бас тэргүүн үе нь урт эгшигтэй байсныг анхаарна уу.

4. Эхний *čayassun хэлбэрээс гийгүүлэгчийн нийлэмж нь *-ss- > -ls- > -s- зэргээр хувьссан байдлаас -S- хэлбэрт аялгуу, бас сүүлчийн *čayarsun хэлбэрээс *-rs- > -rs- зэргээр хөгжсөн байдлаас -R- хэлбэрт аялгуу болон хоёр хуваагдан хөгжсөн бололтой. Үүнийг монгол төрөл хэлний төв аялгуу болон хойд зүгийн аялгуу гэж тус тус нэрлэв. Тийм учраас Мо. *čayalsun ~ *čayarsun гэж -l- ~ -r- хоёр гийгүүлэгч сэлгэсэн хэрэг огт биш гэж үзэв.

5. В: kegde хэлбэр нь эртний уйгур хэлнээс эртний монгол хэлээр дамжин дундад үеийн монгол хэлэнд орж ирсэн бөгөөд тэр нь одоогийн бао-ань, дуншаан, канжя зэрэг гурван хэлэнд бүрэн хадгалагджээ. Үүнийг монгол төрөл хэлний өмнө зүгийн аялгуу гэж нэрлэв. Харин одоо үеийн монгол хэлэнд энэхүү үг хэрэглэгдэхээ байчхаад, бараг мартагдсан үг болсон байна.

6. Харин хуудас (sheet of paper; page) гэдэг үгийн тухайд энэ нь гаднын харь үг биш, монгол хэлний жинхэнэ уугуул үг мөн хэмээн дүгнэсэн болно.

Товчилсон үг:

АТ. ... эртний түрэг хэл (Ancient Turkic)

AUig. ... эртний уйгур хэл (Ancient Uighur)

АМо. ... эртний монгол хэл (Ancient Mongolian)

ММо. ... дундад үеийн монгол хэл (Middle Mongolian)

MHT ... *Монголын нууц товчоо (The Secret History of the Mongols)*

MqMo. ... *Мукаддимат ал-Адаб толь* дахь монгол хэл

MqTur. ... *Мукаддимат ал-Адаб толь* дахь түрэг хэл

Mo. ... монгол бичгийн хэл (Written Mongolin)

Ma. ... манж бичгийн хэл (Written Manchu)

Ch. ... хятад хэл (Chinese language)

Kh. ... монгол хэлний халх аялгуу (Khalkha Mongolian)

Ott. Turk. ... осман түрэг хэл (Ottoman Turkish)

Jap. ... япон хэл (Japanese language)

N ... нэр үг (Nominal class)

V ... үйл үг (Verbal class)

* Тус өгүүлэлд түрэг төрөл хэл, монгол төрөл хэл, манж-түнгүс төрөл хэлний зарим жишээг ямар толиос эшилснийг дурдалгүй орхив.

Зүүлт

- 1) Wiktionary, <https://en.wiktionary.org/wiki/цаас>
- 2) Түүнээс гадна эртний Египетэд МЭӨ 3000 оноос хойш папирусын ишээр хийсэн “*папирус цаас*”-ыг (“Paper” гэдэг үгээс гарал үүсэлтэй), бас МЭӨ II зууны үед Бага Азийн Пергамумд үүсэж, Ромын үеэс эхлэн хонины элдсэн арьсаар хийсэн “*илгэн цаас*”-ыг (үүнийг “Parchment” гэдэг) тус тус хэрэглэж байсан. Сүүлдээ 751 оны Таласын тулалдааны дараагаас хятадаас гаралтай “*цаас*” хийх арга Исламын ертөнцөд нэвтэрсэн түүхтэй.
- 3) Монгол бичгийн хэлний жишээг доорх толиос эшлэв.
I.J.Schmidt (1835), O.M.Ковалевский (1844), K.Ф.Голстунский (1895), F.D. Lessing (1960)
- 4) Үеийн төгсгөлд орсон хажуугийн гийгүүлэгч *-l- нь Миньхэ монгол хэлэнд -r- болж, -er [ə] дуудлагатай болсон байна. Үүнд: #...CVr < #...CV*l.
- 5) Дээрх b) -Ø- (тэг) хэлбэртэй цаасун гэдгээс эвенк, орчон, тува хэлэнд авиа зүйн хувьд ийнхүү хувьссан байна. Үүнд: saazun (2) ← saasun (1) ← цаасун → цаасун (3) / 1. эвенк хэл, 2. тува хэл, 3. орчон хэл
- 6) 7.1.2 Үгийн төгсгөлийн [-z] авианы хувьсал, 7.1.4 Эртний монгол хэлэн дэх цаас (paper) гэдэг үгийн хэлбэр ба хэрхэн хувьсаж хөгжсөн талаар гэсэн 2 хэсгээс үз.
- 7) Үгийн эхний гийгүүлэгч *k- > (*kj- >) ц-ийн тагнайшил (palatalization) нь энэтхэг-европ хэлнүүд (Indo-European languages)-эд ч түгээмэл харагдаж байна. Жишээ нь: 1. [k-]:[tʃ-]-ийн тагнайшил / kaas [ka:s] (Dutch), Käse [kɛ:zə] (German), cheese [tʃi:z] (English) “бяслаг”; Kirche [kɪrçə] (German), chiesa [kʲɛzɔ] (Italian), church [tʃɜ:ʃ] (English) “сүм”, 2. [k-]:[ʃ-]-ийн тагнайшил / castle [kæsl] (English), château [ʃato] (French) “цайз, ордон”; cat [kæt] (English), chat [ʃɑ] (French) “муур”, 3. [g-]:[ʒ-]-ийн тагнайшил / garden [gɑ:dn] (English), jardin [ʒɑrdɛ̃] (French) “цэцэрлэг” гэх мэт.
- 8) Түүнээс гадна эртний түрэг хэлний AT. t гийгүүлэгч нь монгол хэлэнд орохдоо Mo. ц болж тагнайшсан нь бас бий. Жишээ нь: AT. *tigraç* “сильный, крепкий” > **tigiraç* → NYMo. *či'iraq* (赤亦^赤刺^黑) 《實》 → Mo. *čigiraç* (чийрэг) “strong, sturdy” / AT. *tiq-* “набивать” > MqMo. *čiqi-* (< *čiqiqsan*) (266b) “набитое” → Mo. *čiki-* (чихэ-) “stuff” гэх мэт.
- 9) Түүхээс үзвэл Османы эзэнт гүрэн XV-XIX зууны сүүлч хүртэл Балканы хойг дахь Сербийг захирч байсан тул серби, хорват (Serbo-Croatian) хэлэнд осман түрэг хэлнээс нэлээн олон үг орсон байдаг.

- 10) XIII зуунаас өмнөх үеийн монгол хэл (Pre-thirteenth-century Mongolian) нь дундад үеийн монгол хэл (Middle Mongolian)-нээс өмнөх үеийн *таамагласан монгол хэл* бөгөөд үүнийг **эртний Монгол хэл (Ancient Mongolian)** гэж нэрлэе.
- 11) Жишээ нь: латин хэлний ганц тоо: *flōs* “flower”, олон тоо: *flōrēs* “flowers” гэдэг хэлбэрийг *flōs* → **flōs-ēs* > *flōrēs* гэх зэргээр хоёр эгшгийн хооронд /s/ > /z/ > /r/ болж хувьсаж үүссэн гэж үздэг байна.
- 12) 華夷訳語 (*Hua-yi yi-yu*) дээр бас *niri'un* (你^𠬞里温) (1:08b8), 《屋脊》(ger-ün *niri'un*) “roof ridge” гэж гардаг бөгөөд тухайн үед угаасаа *niri'un*, *nirisun* гэсэн хоёр хэлбэртэй байснаас хүний нуруу “spine, back of body”-г илэрхийлэхдээ *nirisun* (你^𠬞里孫) гэсэн хэлбэрийг хэрэглэж тэмдэглэсэн гэж үзэж байна.
- 13) Цуваа цагийн үүднээс үзэхэд ер нь гийгүүлэгчийн нийлэмж **-ls-**ийн эхний гийгүүлэгч **-l-** гээгдэж **-s-** болох нь элбэг тохиолддог юм. Жишээ нь: латин хэл /-ls-/ > франц хэл /-s-/ : латин *pulsare* /pulsɑːre/ “knock” > франц *pousser* /puse/ “push”, латин *salsus* /ˈsalsus/ “salty” > франц *sauce* /sos/ “sauce” гэх мэт.
- 14) Мо. *mösün* (мөс) “ice”, МНТ *mölsün* (2:05:10), хүжү монгол *mol̥si* [mol̥si] (~ *mol̥zi* [mol̥dʒi]) / Мо. *sösün* (цөс) “gall, bile”, МqMo. *sölsün* (446b), хүжү монгол *suul̥zi* [suːldʒi] гэх мэт.
- 15) МqMo. *haryal* (182a), бао-ань *hargal*, дуншаан *haryga* (< **haɮcaɮ* < *haɮcaɮ*), канжя *halva* (< **haɮcaɮ* < *haɮcaɮ*), хүжү монгол *xargal*, миньхэ монгол *khagher* [qɑqɑ] (**qɑcaɮ* < **qɑcaɮ* < **hɑcaɮ* < **haɮcaɮ*), зүүн ёгор *hargal*, дагуур *xaryal* / kh. *аргал*, буриад *аргал* / тод бичиг *arγaᠰun*, халимаг *aphcн*, ойрд [ɑɣɑsn], хөхнуур [ɑɣɑs] “dried cow dung” гэх мэт.
- 16) ***-rs-** > **-rs-** > **-s-** болж хувьссан цөөн жишээнээс эш татвал: Мо. *niγursun* “spinal cord” (> Ма. *ikürsun*), халимаг *нуһрсн*, буриад *нугарһан*, зүүн ёгор *nurgusun* (< **nuγursun* < **niγursun*), дагуур *nokf* (< **nuγursu*) / Мо. *nuγusun*, Kh. *нугаг* (нурууны) гэх мэт.
- 17) Энэхүү үгийн төгсгөлийн гийгүүлэгч нь Tur. **-z-** > Мо. ***-rs-** > **-rs-** гэж хувьссан бөгөөд дүрмийнх нь дагуу **-r-** авиа гээгдээгүй байна. АТ. *münjüz* “horn” → МqTur. *münjüz* > Мо. *mögersün* “cartilage”, Kh. *мөгөөрс*, миньхэ монгол *muerguersi* [muə-ɡuə-si], үзэмчин *мөөрс*, халимаг *мөөрсн*, буриад *мэнгээрһэн*, хамниган (орос) *мүнгөөрсэ(н)*, хүжү монгол *mungirsi* [mʊŋirsɪ] (~ *mungirzi* [mʊŋirdʒi]), дагуур *təmf* (< **mɛbüci* < **mɛbürsü* < **megürsün*) гэх мэт. Зарим хэлний үгийн дунд, жишээлбэл: буриад, хамниган (орос), хүжү монгол хэлний /-ŋg-/ авиа нь бүгд АТ. /-ŋ-/ авианаас үүсэлтэй буй заа.
- 18) Монгол-манж-хятад хэлний толь бичгийн жишээнүүдийг KURIBAYASHI Hitoshi-ийн <http://hkuri.cneas.tohoku.ac.jp/articles/> гэсэн цахим сангаас эшилсэн болно.
- 19) Ch. 羊皮金-ийн тухай мэдээг дараах сайтаас үз.
「材質工藝 全部 皮金繡」 <http://biftmuseum.com/technics/detail?sid=55&pid=0>
「聊聊羊皮金」 <http://www.meipian.cn/4zgehipe>
- 20) “sheepskin (parchment)” буюу “илгэн цаас”-ны тухай товч тайлбарыг зүүлт 2)-аас үз.
- 21) Эрт үед модноос яаж цаас гаргаж авдаг байсан тухай дараах сайтаас үз. Цаасыг хэрхэн хийдэг вэ. <https://tecnobits.com/mn/цаасыг-хэрхэн-хийдэг-вэ%3F/>
- 22) Энэхүү идэвхгүй язгуур *хуу* гэдэгт **-л-** залгаж тусах үйл үг: *хуул-*, **-pa-** залгаж эс тусах үйл үг: *хуур-* бүтээдэг ёс үндсэндээ монгол төв аялгуунуудаас гадна монгол төрөл хэлний хүжү монгол, миньхэ монгол хэл болон зүүн ёгор хэлэнд ч сайн хадгалагдаж байна. Үүнд:
хүжү монгол: *haul̥i*- [xɑul̥i-] 剥皮 / *haur̥aa*- [xɑur̥ɑː-] 脱皮, 脱落
миньхэ монгол: *khueɾ*- [qɑə-] 剥皮 (< **qūl̥*- < **qa'ūl̥*-) / *khaora*- [qɑora-] 脱落

зүүн ёгор: [xu:l-] 剥, 剥皮 / [xu:ra-] 脱落, 剥落 гэх мэт.

- 23) Ийм төрлийн идэвхгүй язгуур нь *хага*, *хуга*, *хуу* гэдгээс гадна, *бут*, *хэмх* ~ *хамх*, *бялба* ~ *балба*, *бяц*, *няц*, *зад*, *дэлбэ*, *эмт*, *нуга*, *суга*, *тас*, *ховх*, *мүлт*, *цоо*, *цуу*, *нэвт* гэх мэт үгс нь монгол хэлний өвөрмөц дайвар үг буй заа.
- 24) Манж бичгийн хэлэнд *hoošari moo* [< *hoošari* “制紙的” (for papermaking) + *moo* “樹” (tree)] гэдэг үг бий. Энэ нь *hoošan* “紙 paper” гэдгийн цорын ганц үүсмэл үг бөгөөд “楮樹” (paper mulberry, Mo. *üsütü duryana*) гэсэн утгатай. Энэхүү модны хальсаар цаас хийдэг гэнэ. Араас нь залгасан *-ri* дагавар нь нэрээс жинхэнэ нэр юм уу, тэмдэг нэр бүтээдэг бөгөөд голдуу олон тоо (plurality) заах утга илэрхийлдэг. Тийм учраас үүнийг үндэс болговол Ма. *hoošari* (*moo*) гэдгийн уг утга нь “олон цаас үйлдвэрлэх (мод)” гэсэн утгатай бололтой.
- 25) Монгол хэлний үйлээс нэр бүтээх *-dasun* дагавар нь утгаа **-dal* (V-N suffix) *-sun* (N-N suffix) гэсэн нийлмэл дагавар байснаа сүүлдээ *-ls-* > *-s-* дүрмийн дагуу **-dal-sun* > *-dasun* болж хувьссан бололтой. Жишээ нь: Mo. *jaru-* (зара-) “to employ; to spend” > *jarudal* (зардал) “expense” > **jarudal-sun* > *jarudasun* (зардас) “servant” гэх мэт.
- 26) Үгийн дундах Mo. *-rg-/-ry-* > Ма. *-j-* болох бас нэг жишээг татвал: Mo. *tergen* (тэрэг) “vehicle; cart” > Ма. *sejen* “wagon, cart”, Mo. *torγa* (торго) “silk” > Ма. *suje* “silk” гэх мэт. Ташрамд хэлэхэд Mo. *t-* > Ма. *s-* / #_V.ᠵ... болдог бас нэг дүрэм байдгийг тэмдэглүүштэй байна.

Ном зүй

А. Монгол хэлээр:

- Лувсанвандан, Ш.** (1968). *Орчин цагийн монгол хэлний бүтэц, Монгол хэлний үг нөхцөл хоёр нь*, Улаанбаатар [Luvsanvandan, Sh. *Orchin tsagiin mongol helnii бүтэц, mongol helnii үг нөхцөл хоёр нь*, Ulaanbaatar: 1968.]
- Өнөрбаян, Ц.** (2021). *Монгол үгийн гарал судлалын үндэс*, Улаанбаатар [Önörbayan, Ts. *Mongol ügiin garal судлалын үндэс* [Foundations of Mongolian Etymology]. Ulaanbaatar: 2021.]
- Ринчен, Б.** (1966). *Монгол бичгийн хэлний зүй, Гутгаар дэвтэр: Хэлбэр судлал*, Улаанбаатар [Rinchen, B. *Mongol bichgiin khelnii zүй, Gutgaar devter: Khelber судлал* [Grammar of the Mongolian Script, Volume III: Morphology]. Ulaanbaatar: 1966.]
- ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн.** (1966). *Орчин цагийн монгол хэл зүй*, Улаанбаатар [Institute of Language and Literature, Mongolian Academy of Sciences. *Orchin tsagiin mongol khel zүй* [Modern Mongolian Grammar]. Ulaanbaatar: 1966.]
- Төмөртоого, Д.** (2018). *Монгол хэлний үгийн гаралын тайлбар толь*, Улаанбаатар [Tömörtogoo, D. *Mongol khelnii ügiin garalyn тайлбар толь* [An Etymological Dictionary of the Mongolian Language]. Ulaanbaatar: 2018.]
- Цэрэнсодном, Д.** (2000). *Монголын нууц товчоо: эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар*, Улаанбаатар [Tserensodnom, D. *Mongolyn nuuts товчоо: erdem шинжилгээний орчуулга, тайлбар* [The Secret History of the Mongols: Academic translation and Interpretation]. Ulaanbaatar: 2000.]

Б. Гадаад хэлээр:

- Академия Наук СССР. Институт Языкознания** (1969). *Древнетюркский словарь*, Наука, Ленинград [Academy of Sciences of the USSR, Institute of Linguistics. *Drevnetyurkskii slovar'* [Ancient Turkic Dictionary]. Nauka, Leningrad. 1969.]
- Bogadek, F.A.** (1944). *New English-Croatian and Croatian-English Dictionary*, New York
- Golden, Peter B.** (2000). *The King's Dictionary: The Rasulid Hexaglot: Fourteenth Century Vocabularies in Arabic, Persian, Turkic, Greek, Armenian and Mongol*, Brill. 2000.
- Голстунский, К.Ф.** (1895). *Монгольско-русский словарь*, Санкт-Петербург [Golstunsky, K.F. (1895). *Mongol'sko-russkii slovari* [Mongolian-Russian Dictionary]. Saint Petersburg. 2000.]
- Hirth, Friedrich.** (1890). *Die Erfindung des Papiers in China, T'oung Pao*, Vol.1, No.1, 1-14, Leiden [Hirth, Friedrich. *The Invention of Paper in China, T'oung Pao*, Vol.1, No.1, 1-14, Leiden. (1890)]

- Ковалевский, О.М.** (1844). *Монгольско-русско-французский словарь*, Казань: Казанский государственный университет [Kovalevsky, O.M. *Mongol'sko-russko-frantsuzskii slovar'* [Mongolian-Russian-French Dictionary]. Kazan: Kazan Imperial University. 1844.]
- 桑原隲藏** (1968). 『桑原隲藏全集』第二卷 岩波書店 [Kuwabara Jitsuzō. *Complete Works of Jitsuzō Kuwabara*, Volume 2, Iwanami Shoten. 1968.]
- Lessing, F.D.** (1960). *Mongolian-English Dictionary*. [Berkeley: University of California Press. 1960.]
- Ligeti, L., Kara, G.** (1990). Un vocabulaire sino-mongol des Yuan: Le Tche-yuan yi-yu, *Acta Orientalia*, Vol.44, No.3, 259-277, Academiae Scientiarum Hungaricae [Ligeti, L., Kara, G. (1990), A Sino-Mongolian Vocabulary of the Yuan: The Tche-yuan yi-yu, *Acta Orientalia*, Vol.44, No.3, 259-277, Hungarian Academy of Sciences]
- 満都夫, 烏.** (1995). 『蒙古訳語詞典』民族出版社 [Manduqu, U. (1995), *Dictionary of Mongolian Translated Words*, Minzu Publishing House. 1995.]
- Mostaert, A., Rachewiltz, I.de.** (1977), *Le matériel mongol du Houa i i iu de Houng-ou (1389)*, Institut belge des hautes études chinoises, Bruxelles [Mostaert, A., Rachewiltz, I.de. *Mongolian material from the Houa i i iu of Houng-ou (1389)*, Belgian Institute of Advanced Chinese Studies, Brussels. (1977).]
- Ōtake Masami.** (2016a). On Gender and Number Representation in Khitan Adjectives, *Kyoto University Linguistic Research*, Vol. 35, 59-89, Kyoto. 2016.
- 大竹昌巳** (2016b). 契丹小字文献所引の漢人典故, 『KOTONOHA』第160号, 1-18, 古代文字資料館発行 [Ōtake Masami. *Chinese Classical Allusions Quoted in Khitan Inscriptions*, KOTONOHA, Issue 160, 1-18, Institute of Ancient Script Studies. 2016.]
- Поппе, Н.Н.** (1938). *Монгольский словарь Мукаддимат ал-Адаб, Часть I-II*, Труды института востоковедения, XIV, Ленинград [Poppe, Nicholas N. *Mongol'skii slovar' Mukaddimat al-Adab* [Mongolian Dictionary Mukaddimat Al-Adab, Parts I-II]. *Proceedings of the Institute of Oriental Studies* (Volume XIV), Leningrad. 19386]
- Ramstedt, G.J.** (1905), *Mogholica: Beiträge zur Kenntnis der Moghol-Sprache in Afghanistan*, *Journal de la Société Finno-ougrienne*, 23(4), Helsinki [Ramstedt, G.J. (1905), *Mogholica: Contributions to the Knowledge of the Moghol language in Afghanistan*, *Journal of the Finno-Ugrian Society*, 23(4), Helsinki]
- Ramstedt, G.J.** (1935). *Kalmückisches Wörterbuch*, Suomalais-Ugrilainen Seura, Helsinki [Ramstedt, G.J. *A Dictionary of the Kalmyk Language*, Finno-Ugrian Society, Helsinki. 1935.]
- Санжеев, Г.Д., Орловская, М.Н., Шевернина, З.В.** (2015). Этимологический словарь монгольских языков Том I, (А-Е), Институт востоковедения РАН, Москва [Sanzheev, G.D., Orlovskaya, M.N., Shevernina, Z.V. *Etimologičeskii slovar' mongol'skikh yazykov* [Etymological Dictionary of Mongolic Languages, Volume I (A-E)], Institute of Oriental Studies, Russian Academy of Sciences, Moscow. 2015.]
- Schmidt, I.J.** (1835). *Mongolisch-Deutsch-Russisches Wörterbuch, nebst einem deutschen und einem russischen Wortregister*, St. Petersburg [Schmidt, I.J. *Mongolian-German-Russian Dictionary with German and Russian Word Indexes*, St. Petersburg. 1835.]
- Шиятани Шигэки.** (2009). *Монгол хэлийн халхын аялгуун дахь үг бүтээх дагаврын судалгаа (Засварласан хэвлэл)*, Осака [Shiotani Shigeki. *A Study of the Derivational Suffixes in Khalkha Mongolian (Revised Edition)*, Osaka. 2009.]
- Толстой, И. И.** (1957). *Сербско-хорватско-русский словарь*, Москва [Tolstoy, I.I. *Serbsko-khorvatsko-russkii slovar'*. [Serbo-Croatian-Russian Dictionary]. Moscow. 1957.]
- Wilkens, Jens.** (2021). *Handwörterbuch des Altuigurischen Altuigurisch-Deutsch-Türkisch*, Universitätsverlag Göttingen [Wilkens, Jens (2021), *Concise Dictionary of Old Uyghur-German-Turkish*, Göttingen University Press]

В. Цахим мэдээлэл

KURIBAYASHI Hitoshi <http://hkuri.cneas.tohoku.ac.jp/articles/>

「材質工芸 全部 皮金繡」<http://biftmuseum.com/technics/detail?sid=55&pid=0>

「聊聊羊皮金」<http://www.meipian.cn/4zgehipe>

Цаасыг хэрхэн хийдэг вэ. <https://tecnobits.com/mn/цаасыг-хэрхэн-хийдэг-вэ%3F/>
Wiktionary (14 June 2025), <https://en.wiktionary.org/wiki/цаас>